

ХҮННҮГИЙН ТҮҮХЭН ГАЗАР ЗҮЙН АСУУДАЛД

Б.БАТСҮРЭН

Товч агуулга. Хүннүгийн газар усны байршлыг тогтоох судалгааг эрчимжүүлэх, урагш ахиулах үүднээс та бүхэнтэй өөрсдийн хийсэн судалгаанаасаа хуваалцаж байна. Бид энэ удаа м.э.ө. 90 оны Хүннү-Ханьгийн дайн, м.э.ө. 50-иад оны Хүннүгийн дотоодын дайнаар түүхэнд тэмдэглэгдсэн газар усны байршлыг тогтоохын оролдов. Мөн Хүннүд гол, зүүн, баруун гар байсан уу эсвэл зөвхөн хоёр гарын тогтолцоотой юу гэдгийг товчхон хөндөх юм.

Түлхүүр үг. Хүннүгийн хоёр гар, Чжаосинь, Чжигюй ус, Сусеуяньжаны/Суеуяньжаны, Цзоаньхоу, Гуцзюй ус, Юйу, Доусянь, Сидунь, Наогу, Гуцзюй шуй

Нэлээд эртнээс гадаад, дотоодын эрдэмтэд сонирхож судалсаар ирсэн хүннүгийн түүхэн газар зүйн сэдвүүд нь монголын эртний түүхийн нэг салшгүй чиглэл, бүрэлдэхүүн билээ. Тус өгүүллээр, м.э.ө. 90 онд Хань улсаас Хүннүг түрэмгийлэх үед түүхэнд үлдсэн, мөн м.э.ө. тавиад онд болсон Хүннүгийн дотоод иргэний дайны тоймыг өгүүлэхэд дурдсан газар усны байршлыг тогтоох гэж оролдсоноо толилуулж байна. Хүннү гүрний нутаг дэвсгэрийн хуваарь, засаг захиргааны зохион байгуулалтын талаар ч товч өгүүлнэ.

Эхлээд өмнө нь өөрсдийн хэвлэсэн судалгаагаа¹ нэгтгэж толилуулах бодолтой байна. Тэгвэл уншигч нарт арай ойлгомжтой, эмх цэгцтэй, бүрэн дүр зураг буух байх.

2002 он:

Язгуурын хүннүчүүдийн уугуул нутагт орших Цзюньци уул, Саньмулоцзы уул, Чжое уул, Яньжань уул, Юйу гол, Чжицзюй голын талаар санал дэвшүүлсэн өгүүллээ одоо харахул Яньжань уулыг Дундговийн Дэлгэрхангай

¹ Хүннүгийн түүхэнд холбогдох зарим газар усны байршлын асуудалд – *Studia Historica*. Том. 33, Fasc. 19. Улаанбаатар, 2002, т. 195-201; Цюйшэ хэмээх нэрийн тухай нэгэн саналыг нягтлах нь – *Acta Historica Mongolici*. Том. XIII, Fasc. 6. Улаанбаатар, 2012, т. 44-50; Ухуань (Авар) ба Сяньби (Сэрби). “ТЭПЭ” ХХК., Улаанбаатар, 2016, т. 21-24, 35-39; МЭӨ IV-III зууны үеийн Хүннүгийн нутаг дэвсгэрийн тухайд – *Journal of the Archaeology, History and Culture*. Vol. 13(12). Улаанбаатар, 2017, т. 63-70 (Ч.Энхтуулын хамт); 89-91 онд Хожуу Хань улсаас Умард Хүннү улсыг довтолсон түүхийн асуудалд – *Historia Mongolarum*. Том. XVIII, No 537(39). Улаанбаатар, 2019, т. 5-20; Лунчэн (龍城, longcheng) хэмээх хүннү үгийн тухай – *Historia Mongolarum*. Том. XIX, No 19(546). Улаанбаатар, 2020, т. 5-10

(Инэл) уул, Юйу голыг Өмнөговьд буй нэг сайр, Саньмулоцзы уулыг Сэврээ уул гэж үзсэн маань ‘байгаа онож’ харин нөгөө гурвынх нь оноолт ‘төөрч’ будилжээ.

2012 он:

М.э.ө. 203/202 оны орчим Модуны эзэлсэн Хуньюй, Цюйшэ (Кюйшэ), Динлин (Өндөр тэрэгтэн), Гэгунь, Синьли гэсэн, урьд өмнө нь Юэчжийн харьяанд байсан гэж үзсэн таван улсын нэг Цюйшэ/Кюйшэ нь хүннүгийн араар Хакасаас – Байгал нуур хүртэлх нутагт буюу Өмнөд Сибирьт байсан гэдэг мухардсан санал, хол зөрүү төөрөгдлийг үгүйсгэхийг оролдсон өгүүлэлдээ, *цюйшэ* (*скуда/скиф) нар нь Алтайд, Пазырыкийн соёл бүхий бүс нутагт тархан сууж байсан байх хэмээх үзэл дэвшүүлсэн.²

2016 он

М.э.ө. 119 оны дундуур Дай, Юбэйпин хотоос хөдөлж хоёр эсвэл нэг мянган ли зай туулсан 50 мянган хүнтэй ханьгийн их цэрэг (арми)-т ялагдсан хүннүгийн зүүн гарын *ухуань* (*авар)-чуудын нутаг Хянганы зүүн талд биш харин баруун талд нь, XVII-XIX зууны үеийн Үзэмчин хошууны нутаг байжээ гэж үзсэн. Харин Линь Гань, Л.А.Боровкова нар *авар* (ухуань)-чуудыг Шилийн голын чуулганы нутгаар суурьшиж байсан гэж хэлсэн билээ.

2003 онд хэвлэсэн зохиолдоо *‘лан цзюй сюй, гуянь, хань хай’* гэх үгсийг уул, газрын нэр болгож тайлбарласан эрдэмтдийн саналыг дэмжиж, дагасан³ билээ. Өөрөөр хэлбэл, энэхүү мөрүүдийг тэрлэгч 2003 оны үед алдаатай үзэл баримтлал баримталж байсан гэсэн үг.

2016 оны зохиолдоо 2003 оны үзэл баримтлалаа нягталж, холбогдох түүхэн мэдээг тэс өөрөөр тайлж уншсан Л.А.Боровковагийн санал зөв юм байна гэж үзээд дэмжиж эшилсэн юм. Өөрөөр хэлбэл, Хань улсын Хо Кюйбин жанжин тулалдаанд алагдсан цэргээ ил орхилгүй, чоно ихтэй ууланд маш түргэн оршуулж, овоо босгож тахил өргөжээ. Тэгэхдээ уулын хажуу бэлээс шувууны өд их хийсэж байсан газрыг ажиглан суусан⁴ гэх утгатай мэдээний зарим үгийг хожмын судар тайлбарлагч хятад бичгийн хүмүүс болон орчин цагийн гадаадын эрдэмтэн нар газрын нэр гэж эндүүрсэн хэмээн Л.А.Боровкова тайлбарласан байдаг, үүнийг л 2016 онд дэмжсэн юм.

2017 он:

Өгүүллийн эхэнд м.э.ө. IV-III зууны үеийн *хүннүчүүдийн* нутгийг судалсан эрдэмтдийн үзэл, онолыг нягталж, гурав бүлэглэн авч үзсэн. Дараа нь сурвалж, дурсгалын судалгааг үндэслэж *язгуурын хүннүчүүд* нь уулаас одоогийн *халх монголчуудын* нутагт сууж байсан гэсэн санал дэвшүүлсэн билээ.

² Acta Historica сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн төгсгөлийг гэж хэвлэсэн билээ.

³ Батсүрэн Б. Монголын эртний улсуудын нутаг дэвсгэр. ADMON, Улаанбаатар, 2003, т. 81

⁴ 封狼居胥山禪於姑衍登臨翰海 (feng lang ju xu shan chan yu gu yan deng lin han hai)

2019 он:

Умард Хүннү улсыг уулгалан довтолсон *хожуу ханьгийнхны* түрэмгийллийг голлож дурдсан өгүүлэлдээ дашрамаар хэд хэдэн газрын байршлыг тогтоож үзсэн юм. Тухайлбал, 2002 онд Говь Гурван сайхан уул гэж үзсэн Суньги (Цзюньцзи) уулыг Өмнөговийн Их Шанхын нуруу, харин шаньюйн орд өргөө байрлаж байсан Аньси⁵ гол бол Хэрлэнд цутгах Галуут гол (эсвэл Их, Бага Галуут нуур), м.э. I зууны сүүл хагаст шаньюйн орд өргөө шилжин байрласан Аньхоу гол бол Орхон биш харин Харуух (Харбух)-ын гол, умард шаньюйн бүслэгдсэн Ганьвэйхэ гол бол Архангайн Тамирын гол биш харин Өмнөговийн Хармагтын гол, Сюннүхэ гол бол Өмнөговийн Хонгорын гол, Тянь уул нь Говь Гурван сайхан уул, умард шаньюйн хамгийн сүүлд 91 онд бүслэгдсэн Цзиньвэй уул бол Алтайн нуруу биш харин Булганы Хөгнө Тарнын уул, Жое (Чжое) уул бол Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын Тогоо уул гэж үзсэн.⁶

2020 он:

Бараг м.э. III/IV зуунаас⁷ эхэлж ‘лунчэн’ (龍城, longcheng) бол Хүннүгийн шаньюйн орд өргөө, хот гэсэн үзэл бат тогтсон гэхэд болно. Тус үзэл баримтлалыг шүүмжилсэн өгүүлэлдээ бид ‘лунчэн’ бол газрын нэр биш, харин хүннүгийн эрх баригч ихэс дээдэс хурж цуглаад, төрийн хэрэг хэлэлцдэг *хуралдай* (*kʰoŋ.ɕeŋ < *kʰ(ʷ)рулан)-г л заасан эртний монгол (хүннү) үгийг галигласан эртний утга үсгийн галиг юм гэсэн санал гаргасан билээ.

2002–2020 оны хооронд хэвлэгдсэн судалгааны үр дүнд нэгд, *язгуурын хүннүчүүд* нэн эрт цагаас Монгол Улсын нутагт төвлөрч сууж байжээ, өөрөөр хэлбэл, уугуул нутаг нь Монгол гэдэг нь, хоёрт, эртний *ханьгийнхан*, *вэйгийнхний* түүхэд тэмдэглэсэн уул, ус гол, газрын нэлээд нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн төвийн бүсийн өмнүүр болон дунд биеэр байгаа нь тодорч байна. Гуравт, *язгуурын хүннүчүүдийн* улс төрийн төвийг Лунчэн гэж хожим эндүүрснээс болж Луут хот гэсэн домог бүрэн биежиж, үүнд итгэгч монголын судлаачид хэд хэдэн Луут хотыг олоод байгаа нь түүхэн үнэнээс даанч хол зөрүү судалгаа болсныг илрүүлсэн гэж бодож байна. Дөрөвт, Хүннүгийн улс төрийн төв нь Хэрлэн-

⁵ Хүннүгийн шаньюйн орд өргөө байрлаж байсан гэх Аньси гэдэг голын нэр Сыма Цянь-ий бичиж дуусгасан Түүхийн тэмдэглэлийн бидэнд ирсэн хувилбаруудад лав байхгүй. Арай хожмын сурвалжид гарсан.

Цаогийн Вэй улсын түшмэл Юй Хуань гэдэг хүний, м.э. 239-265 онд бичсэн «Вэйгийн товчоон» буюу «Вэй улсын товч түүх (Вэйлюэ, 魏略, weilüe)»-д анх дурдсан гэж болно. Үүнээс өмнөх дурсгалыг одоогоор олж хараагүй.

⁶ Харамсалтай нь 2019 онд хэвлэсэн Historia Mongolarum, tomus XVIII-д нийтэлсэн газрын зургийн зурсан оныг 2020 он гэж эндүүрсэн байдаг. Уг нь миний бие уул зургийг 2018-2019 онд бодож боловсруулж зурсан бөлгөө.

⁷ Ханьгийн түрэмгийллийн эхэнд дөрвөн замаар цэрэглэж Говийн өмнүүр өвөлждөг *язгуурын хүннү* нарыг анх дайлахдаа Вэй Циний хүрсэн сууринг *ханьгийнхан* үнэхээр Лунчэн гэж тэмдэглэжээ. Энэ баримтаар бол м.э.ө. II зууны адаг гэхэд алдаатай энэхүү үзэл баримтлал *ханьгийнхны* дунд хэдийн тогтчихсон байсан гэсэн үг.

Туулын савд ялангуяа м.э. I зууны төгсгөл хүртэл – Хэрлэн мөрний эх⁸ орчим байжээ гэсэн санал дэвшүүлсэн байна.

Гэвч олж тогтоох олон газар ус болон хүннүгийн засаг захиргааны хуваарь (түмтүүдийн байрлал) зэрэг олон асуудал шийдлээ хүлээсээр байгааг дахин тэмдэглэж хэлье.

Хүннүгийн газар усны байршлын талаар өгүүлэхийн урьд *эртний монголчуудын*⁹ төр улсын түүхэн газар зүйн судалгаанд харагддаг ганц нэг онцлогоос дурдъя. Эн тэргүүнд эртний хятад сурвалжид тэмдэглэгдэн үлдсэн эх хэрэглэгдэхүүн (газар нутаг, ус гол, уул, тал хээрийн нэрс) нь Хань улсын түүхэнд хэрэгтэй, дурдах ёстой түүх үйл явдлын далимаар л тэмдэглэгдсэн тул энд тэнд их тарж тэмдэглэгджээ. Хоёрт гэвэл Хань улс хүчирхэгжиж, Хүннүгийн эсрэг түрэмгий дайн эхлүүлсний дараа тэмдэглэгдэж эхэлсэн газар усны нэрс нь Хүннү – Ханьгийн хилээс хойш, умард руу чигтэй агаад Ханьгийн улс төрийн төвөөс улам бүр алсарч холдсон зайтай тэмдэглэгддэг. Өөрөөр хэлбэл, ханьгийн цэрэг чадлын хэрээр хол давшиж хүрсэн газраа хүртэлх нэрийг дурдсан гэсэн үг. Гурав, энэ хэрээр Хүннүгийн газар усны нэр түүхэнд илүү олон үлдсэн юм. Судалгааны хувьд гэвэл тухайн сэдвийг шууд эсвэл дам байдлаар хөндсөн эрдэмтэд бараг бүх газар ус, уул толгод, нуур цөөрөм, хээр талыг одоогийн Монгол Улсын нутаг дэвсгэрийн төвийн бүсийн төв, эсвэл хойд нутгаар эрж хайж, тогтоох ‘тун дуртай’, тэдний заншил, зуршил болсон арга нь юм. Гол нь эдгээр эрдэмтэн газар усны нэрийг галигласан утга үсгийн эртний дуудлага сэргээсэн судалгааг хэзээ ч ашиглаж хэрэглэж үзээгүй гэж болно. Одоо болтол ийм арга хэрэглэсэн судалгаа олж хараагүй л явна. Тэд нар аль нэг түүхэн газар усны байршлыг тогтоогоод (мэдээж тухайн судлаач өөрийн үзэмжээр л асуудалд хандах нь хэтэрхий ойлгомжтой) л орхичихдог гэж болно.

* * *

Түүхийн мэдээ. Хань улсын Уди хаан м.э.ө. 90 оны билгийн улирлын гурван сард¹⁰ (4.17-5.16) их цэргийн хүчээр Хүннүг довтлох шийдвэр гаргаж, зарлиг буулгажээ. Нийт 140 мянган хүнээс бүрдсэн ханьгийн их цэрэг 5-р сараас 7-р сарын 14-ний хооронд гурван газраас зэрэг гарч Хүннүгийн зүг хөдлөв. Эршийн цэргийн захирагч Ли Гуанли далан мянган цэрэг захирч Уюань хотоос; тэргүүн хянагч (шидайфу) түшмэл Шанцю Чэн 30 мянган цэрэгтэйгээ Сихэ-гээс; *чунхэ* гүн Ман Тун 40 мянган

⁸ Барагцаалбал Хэрлэнд цутгах Дунд Байдлаг голын бэлчрээс Галуут гол, Их, Бага Галуут нуурыг дайрч зуу хол давсан км үргэлжлэх Хэрлэн голын баруун тал дагуух газар.

⁹ Эртний монголчууд гэдэг нь – м.э.ө. IV/III зуунаас хойш Монголд төвлөрч суурьшиж байсан монгол хэлтэн *хүннү, сэربي, авар, нирун, табгач* зэрэг олон овог, аймгийг хамруулсан ерөнхий нэр томьёо.

¹⁰ Pan Ku. The History of the Former Han Dynasty. Translation. Volume Two. First division. The Imperial Annals. Chapters VI-X. A Critical Translation with Annotations by Homer H.Dubs. Third printing. Baltimore, Waverly Press, 1969, p. 115; Бань Гу. Хань шу («История Хань»). Том 1. Хроники правления императоров (Ди цзи). Перевод с китайского В.В.Башкеева, под редакцией М.Ю.Ульянова, комментарий, вступительные статьи и приложения В.В.Башкеева, М.Ю.Ульянова. Москва, ИДВ РАН., Вост. лит., 2021, стр. 244

морьт цэрэг дагуулан Цзюцюань-аас хөдөлжээ. Тэд нар ханьгийн хил дагуу барьсан бэхлэлт хэрмийг давж, тус бүр *мянгаад* ли хол газар зорчжээ.¹¹

Ханьгийн дунд замын цэрэг. Шанцю Чэний захирсан цэрэг Уди хааны намтарт өгүүлснээр бол Суньги уул хүрчээ. Харин Хүннүгийн бүлэгт дурдсанаар бол түүний их цэрэг Чжуйсецзин хүрчээ. Буцахад нь хүннүгийн *дагян* болон Ли Лин хоёрын захирсан 3 түмт цэрэг¹² нэхэж Суньги ууланд гүйцээд тэндээс эхэлж тасралтгүй 9 өдөр дагаж, мөшгөн хатгалджээ. Ханьгийн цэрэг ухарсаар хилийн дэргэдэх Пуну гол хүрэхэд *хүннүчүүд* сая дайснаа орхиж нутаг буцсан байна. Амжилтгүй дайн байлдаанаа их бүрхэг бөгөөд цухас дурдаж, бичисхийгээд орхичихдог ханьгийн түүх бичлэгийн уламжлалаар бол *хүннүчүүдийн* завдал өгөлгүй мөшгөн хатгалдсаныг нууж, «амжилт олоогүй тул буцсан» гэх цөөн үгээр үйл явдлыг хааж төгсгөжээ.

Ханьгийн баруун замын цэрэг. Ханьгийн хааны ордонд боловсруулсан төлөвлөгөө ёсоор бол Ман Тун¹³ дөрвөн түмэн морьт цэргээр Цзюцюаниас гараад Чэшийн араар, өөрөөр хэлбэл, Хами, Бархөлөөр дамжиж давшиж Ар Чэши улсыг довтлох ёстой байжээ. Өвөр Чэшийг, 99 оноос өмнө Хань улсад урваж Кайлин гүн хэргэм хүртсэн хүннүгийн харьяат Гайхо ван довтлох ёстой байжээ. Тэрээр Лоулань (2912 цэрэгтэй), Вэйсюй (2000 цэрэгтэй), Юйли (2000 цэрэгтэй), Карашахр (6000 цэрэгтэй), Шаньго (100 цэрэгтэй) зэрэг 6 эзэмшлийн цэргээс бүрэлдсэн ангиудыг захирч Өвөр Чэшийг эзэлснээр тэд хүннүгийн харьяанаас гарч ханьгийн мэдэлд оржээ. Харин Ман Туны цэрэг урагшилсаар Тэнгэр уул хүрэх үед *хүннүчүүд*, тус бүр өөрсдийн түмтээ захирах зүүн, баруун *хучжи* (呼知, huzhi) вангуудыг Янькюй (Яньцюй) *дагянд* захируулж зам тосон илгээжээ. Ханьгийн түүхчдийн мэдээлэхээр бол *хүннүчүүд* ханьгийн их цэргийг хараад ухарсан тул Ман Тун юу ч олоогүй гэнэ. Хами хавийн ууланд хоёр талаас тулсан цэрэг бие биеийн замыг хааж хэсэг байцгааснаа тус тусын нутаг руугаа ухарсныг ийн өгүүлсэн бололтой. Ингэснээр *хүннүчүүд* Өвөр Чэшиг *ханьгийханд* алдсан ч Ар Чэшиг авч үлдсэн тул хүннүгийн хоёрхон түмт (ө.х. 4–8000 хүнтэй нэг дивиз) үүргээ тун амжилттай биелүүлсэн гэсэн үг.

Ханьгийн зүүн замын цэрэг. Хүннүг түрэмгийлэн довтолсон Хань улсын 3 замын цэргээс Ли Гуанлийн захирсан 70 мянган хүнтэй армийн оролцсон байлдаан чухал бөгөөд түүнийг дэлгэрэнгүй өгүүлээд дараа нь ханьгийн түрэмгийлэгч армийн дайрч өнгөрсөн газрын байршлыг олохыг оролдъё.

Хүннүгийн баруун гарын *их дувэй* ноён, Вэй Люй хоёрын захирсан цэрэг ханьгийн армийн замыг тосож хөдөлснийг мэдсэн Ли Гуанли тэдний эсрэг 2 мянган ху аймгийн цэрэг илгээжээ. Тэр 2000 цэрэг хүннүгийн 1500 орчим цэрэгтэй Фуянь-ий Гоу (Фуяньгоу) уулын хавцалд байлдав. Ялагдаж, нэг хоёр

¹¹ Ханьшу, 94А, 3776; Таскин В.С. Материалы по истории сюнну (по китайским источникам). Выпуск второй. Предисловие, перевод и примечания. Москва, Издательство «Наука», ГРВЛ, 1973, стр. 20

¹² 6-12 мянган цэрэг гэсэн үг.

¹³ Баруун хязгаарын тэмдэглэл болон Удигийн намтарт – Ма Тун гэж бичжээ.

зуун цэргээ алуулсан *хүннүчүүд* ухарчээ. Ханьгийн цэрэг ухрагсдыг мөшгөсөөр Фаньфужэнь бэхлэлт хүрэхэд *хүннүчүүд* дахиад ухарч алга болжээ.

Явах замаа ингэж цэвэрлэсэн Ли Гуанли цэргээ дагуулан Хүннүгийн нутагт цөмөрч Чжигюй усыг чиглэж давшсаар нэг газар (?) буужээ.

Цэрэг ирж явааг мэдэж, замд нь саад болж цаг хожих зуур *хүннүчүүд* дайны хөлөөс зайлж амжсан тул ханьгийн цэрэг хэнтэй ч таарсангүй. Улмаар сударт нэрийг нь бичээгүй газар хүрч буужээ. Тэгээд, Ли Гуанли 20 мянган шилдэг морьт цэрэг ялгаж *хуцзюнь жанжсин* (護軍將)-д өгч, “Чжигюй хүрч өнгөр (度, dù)” гэж тушааж, *хүннү* нарыг хайхаар илгээв. Гэтэл холдож амжаагүй байхад нь *зүүн сэцэн ван*, *зүүн дагян* хоёрын захирсан хүннүгийн нэг дивиз¹⁴ тосож өдөржин байлдав. Тулалдаанд хүннүгийн *дагян* ноён алагдсан ч 20 мянган цэрэгтэй хөдөлсөн ханьгийн шилдэг корпус ухрахаас өөр аргагүй болж буусан буудал өөдөө тэмүүлжээ. Ингээд явсан, буудалласан цэргээ нэгтгэж авсан Ли Гуанли жанжин ч гэсэн ухарч эхлэв. Чжигюй-н барааг ч хараагүй *ханьгийнхан* ухарсаар Сусеуяньжань уул хүрчээ. Тэнд түр бууж амрах агшинд 5 түмт¹⁵ цэрэг цуглуулж амжсан Хулугу шаньюй нэхэж гүйцээд ханьгийн армийг бүсэлж, буцах замыг нь хааж, тулалдахаар зэхжээ.

Ханьгийн булаан эзлэх арми Хүннүгийн нутагт цөмрөх агшнаас – Сусеуяньжань ууланд бүслэгдэх хүртэлх хугацаанд хүннүгийн Хулугу шаньюй ямар арга хэмжээ авсныг «Хань улсын бичиг»-т тэмдэглэж үлдээжээ. Их цэрэг дайлаар ирж буйг мэдсэн хүннүгийн шаньюй эхлээд бүх тэрэг, ачаа хөсгөө Чжаосинь бэхлэлтээс хөдөлгөж, Чжигюй усанд буусан орддоо зөөж хураажээ. Дараа нь Хулугу цэргээ цуглуулж, биечлэн захирч мордоод ханьгийн цэргийг нэхжээ.

Хулугу-г ингэж байхад *зүүн сэцэн ван* мөн харьяат иргэдээ нүүлгэж Юйу-г дайрч өнгөрөөд, тэндээс 600-700 ли зайтай байдаг Доусянь ууланд байрлуулжээ. Дараа нь *зүүн дагян* ноёны хамт 4-8 мянган цэрэг дагуулж шаньюйд туслахаар давшиж, ханьгийн *хуцзюнь жанжны* 20 мянган цэрэгтэй эхэлж тулалдсан юм. Өөрөөр хэлбэл, шаньюй эхлээд нэг хороо цэрэг илгээж, ханьгийн их армийн замыг хааж цаг хожиж байхдаа Чжаосинь бэхлэлтээс ачаа хөсгөө зөөж амжсан бол төд удалгүй давшиж ирсэн ханьгийн цэргийн манлай корпусыг *зүүн сэцэн вангийн* захирсан хүчээр тосож тулалдан бас л хугацаа хожжээ. Тэгэх зуур ойр орчмоосоо арваас хориод мянга буюу 5 түмт цэрэг цуглуулжээ. Улмаар буцаж байсан ханьгийн аялан байлдах армийг шил даран нэхэж довтолгоод Сусеуяньжань ууланд гүйцжээ. Хүннүгийн цэргээс арай өмнө Сусеуяньжаньд ирж буугаад амарч эхэлсэн ханьгийн цэргийн орж гарах гарцыг, гүйцэж ирсэн *хүннүчүүд* хааж бүсэлсэн байна.

¹⁴ Ханьгийн хуцзюнь жанжны захирсан 20 мянган хүнтэй корпусыг, хүннүгийн дөрвөн мянга, эсвэл найман мянган хоёр түмт цэрэг тосож байлджээ. Хоёр түмт нь орчин цагийн нэг дивиз гэсэн үг.

¹⁵ Орчин цагийнхаар бол – арваад мянган хүнтэй нэг *дивиз* юм уу эсвэл хориод мянган хүнтэй *корпус* гэсэн үг.

Суеуяньжань ууланд байрласан ханьгийн цэрэгтэй *хүннүчүүд* маш хүнд¹⁶ тулалдаан хийснийхээ дараа, шөнө нь хоёр тал түр амсхийснийг ашиглаж дайсныхаа өмнө хэдэн тохой гүн гуу суваг татаж дуусгаад *хүннүчүүд* гэнэт дайрч довтлов. Ханьгийн цэрэг ухарч зугтахдаа ухсан гуу нүхэнд олноороо унаж бэртсэнээр ханьгийн цэргийн байлдааны журам эвдэрч хиар цохиулжээ. Ли Гуанли ч бууж өгөв.

Тус бүр 30, 40 мянган хүнтэй ханьгийн эзлэн түрэмгийлэгчдийн хоёр ч корпусыг ялж, гол армийг нь бүрэн устгасан Хулугу шаньюй дараа жил нь Хань улсад шаардлага¹⁷ хүргэж Уди-г шахамдуулсан нь м.э.ө. 90 оны дундуур болсон байлдааны улс төрийн гол үр дүн ажээ.

Гэхдээ өгүүллийн маань жинхэнэ зорилго бол энэ үйл явдлаар тэмдэглэгдсэн газар усны байршил.

Эдгээр газар усны байршлын талаар судлаачид ямар санал гаргасныг сонирхсон хойно өөрсдийн таамаглалаа хэлье. «Хань улсын бичгийн» Хүннүгийн бүлгийг англи хэлэнд буулгасан Жозеф П.Яп – Чжигуй-г Сэлэнгэ мөрөн, Гуце-г Архангайн баруун хэсэгт байдаг нэгэн гол гэжээ. Суньги (Хунji/Цзюньцзи) уулыг Туул голын савд байгаа уул гэсэн бусад эрдэмтний тайлбарыг эшилсэн ч өөрөө болохоор Суньги-г Алтайн дунд хэсгийн нэг уул гэжээ.¹⁸

Хань улсын бичгийн хэдэн бүлгийг монголчилсон Г.Элдэв-Очир, Чжигуй-г “одоогийн Сэлэнгэ мөрний баруун урсгалын¹⁹ нэр”, Доусянь уулыг “Туул голын дээд урсгал орчмын нутаг”, Гуце/Гуцзюй-г “одоогийн Баянхонгор аймгийн нутгаар урсаж Орог нуурт цутгадаг Түйн гол”, Суньги уулыг Алтайн нуруун нэг уул гэжээ.²⁰ Байгаа оноогүй, хятадын түүх бичлэгийн нөлөөтэй тайлбарууд болжээ. Зөвхөн энэ 2 судлаачийн ажил ч биш тухайн сэдвийг хөндсөн бараг бүх судалгаа нэг иймэрхүү ‘тэнэж, төөрсөн’ ажил байдаг учир нэг бүрчлэн дурдах шаардлагагүй гэж бодож байна.

Шанцю Чэн-ий захирсан ханьгийн дунд замын цэргийн хүрсэн хамгийн хол газрыг Чжуйсецзин, (追斜/邪徑, zhuixiejing) гэж сурвалжид тэмдэглэжээ. Суньги²¹

¹⁶ Хань улсаас анх мордохдоо далан мянган хүнтэй байсан ханьгийн аялан байлдах армитай, богино хугацаанд татаж хуралдуулсан нэг дивизээс – нэг корпус хэрийн хүчээр *хүннүчүүд* тулалдсан учир яах аргагүй хүч шавхсан, зууралдсан илд мэс түлхүү хэрэглэсэн ойрын зайн гардан тулалдаан давамгайлсан хүнд байлдаан болсон нь үнэн л болов уу.

¹⁷ Хүннүгийн өмнөх хаадын үед тогтоосон, Хань улсаас авдаг байсан хахуулийн хэмжээг нэмсэн шаардлага хүргүүлсэн гэдэг.

¹⁸ Yap, Joseph P. The Western Regions, Xiongnu and Han. A Collection of Chapters from the Shiji, Hanshu and Houhanshu. Translated and annotated. 2019, p. 330 notes 146, 148, 150

¹⁹ Голын эх, адаг эсвэл дунд бие гэж ярьж бичдэг биш билүү. Баруун, зүүн урсгал гэж бичих нь их л ховор шиг санагдана.

²⁰ Бань Гү. Баруун Хан улсын бичиг. II. Хятад хэлнээс орчуулсан Г.Элдэв-Очир. УБ., “Удам соёл”, 2020, т. 304-305

²¹ Жозеф П.Япын Хунji гэж буулгасан уулын нэрийг Н.Я.Бичурин Суньги (Сюньги) гэж буулгасан. Яагаад ингэсэн талаар Иакинф өөрөө тайлбар хэлээгүй бол А.Г.Малявкин 1989 оны зохиолдоо дараах тайлбарыг толилуулжээ. Тэрээр, “Цзюньцзи” гэдэг үгийг Н.Я.Бичурин “Суньги” гэж уншсан нь алдсан хэрэг огт биш, харин ч ухамсартайгаар авч хэрэглэсэн уншлага. Ер нь Н.Я.Бичурин их олон нэрийг өмнөд аялгууны үүднээс уншсан байдаг. Тэгээд ч С.Вильямсийн толь бичгээс “цзюнь” (浚, jun) гэдэг утга үсгийг Амой, Сватоу аялгуунд “sün” гэж дууддаг болохыг харж хэмээн бичсэн (Малявкин А.Г. Танские хроники о государствах Центральной Азии. Тексты и исследования. Новосибирск, «Наука», Сибирское отделение, 1989, стр. 137).

уулын ард байрлах газар. Тиймээс Суньги уулаар баримжаалж олно. М.э.ө. 103 онд анх түүх сударт тэмдэглэсэн тус уулыг Шофанаас баруун хойш 2000 ли зайтай байдаг гэж нэг баримтад дурджээ. М.э.ө. 99 оны баримтаар Гюйяниас 30 хоногийн зайтай газар байдаг уул²² болохыг мэдэж болно. 30 хоногийн хувьд *арбалетаар* зэвсэглэсэн 5 мянган явган цэргийн зарцуулсан хугацаа. Морьтны хоногт явах газраар баримжаалж тооцоолж болохгүйг гадаадын нэртэй судлаачид анзаарах эсвэл анзаардаг л байлгүй дээ.

Суньги уулыг манжийн түүхч Дин Цянь – Арцбогд (Аланьча богд) уул гэснийг В.С.Таскин, А.Г.Малявкин нар дурдсан. 2002 оны өгүүлэлдээ алдсан бид дахин нягталж үзсэн судалгаагаа 2019 оны өгүүлэлдээ тусгаж Шанхын уул гэсэн. Утга үсгийн дуудлага сэргээдэг С.А.Старостин (1953-2005), А.Шюсслер (1940 онд төрсөн) гэдэг хоёр эрдэмтний толиор бол Суньги (Цзюньци, 浚稽, junji) гэдэг үгийн м.э.ө. II – м.э. I зууны үеийн дуудлага *swənh.kjəj (WH), *suin.ki (LH) гэж сэргээгдэх нь монгол–кириллээр шунх (шанх?) хэмээн бичдэг үгтэй төстэй ч юм шиг.

Чжуйсецзин гэдэг үгийг эрдэмтэд – газрын нэр мөн, эсвэл биш гэж хоёр янз үзсэн байдаг.

Жэнжан Шанфан (1933-2018, 郑张尚芳, zhengzhang shangfang)-ы эртний (ОС) дуудлагын тольд²³ *чжуй-се-цзин* гэх гурван үсгийг орчин цагт ‘толгойн’²⁴ гэж бичдэг үгтэй их дөхүүгээр сэргээжээ. Харин утга үсгийн хожуу эрт (ОСМ), хожуу хань (LH)-гийн дуудлагын А.Шюслерийн толь бичгийн²⁵ сэргээлтээр бол ‘толгойн’ гэхээс гадна ‘туулай’ ч байж мэднэ.

Гэхдээ байр зүйн зургуудад Шанх уулын ард холгүйхэн²⁶ Толгой нэртэй газар нэг хоёроор тогтохгүй тэмдэглэгджээ. Тэдний нэгэнд нь Хань улсын цэрэг хүрчээ.

Чжуйсецзин-ий сэргээлт:

ОС	*tul.laa.keəŋs	(Old Chinese Phonology, 573, 538, 380)
ОСМ	*tûi.la.kêŋh, LH *tui.ja.keŋ	(Minimal Old Chinese, 28-12, 1-47, 9-1)

Чжаосинь [бэхлэлт-хот]. Өмнөговь аймгийн Номгон сумын төвөөс урагш гучаад км зайтай байдаг Баянбулагийн нуурийг 1990 онд малтсан ба Д.Цэвээндорж нар «ШУА-ийн мэдээ» сэтгүүлийн 1994 оны 3-4 дугаарт Баянбулагийн нуурийг Чжаосинь “балгас байж магадгүй бололтой” гэж дүгнэсэн өгүүллээ хэвлэсэн.²⁷

²² Таскин В.С. Материалы по истории сюнну (по китайским источникам). Предисловие, перевод и примечания. Москва, Издательство «Наука», ГРВЛ., 1968, стр. 59, 150 комм. 204; Таскин В.С. Материалы по истории сюнну (по китайским источникам). Выпуск второй. Предисловие, перевод и примечания. Москва, Издательство «Наука», ГРВЛ., 1973, стр. 111

²³ Zhengzhang Shangfang. Old Chinese Phonology. Shanghai, Shanghai Educational Publishing House, 2003 (郑张尚芳《上古音系》，上海：上海教育出版社，2003), бичвэрт Old Chinese Phonology гэж товчилно.

²⁴ Бас ‘дулаан’, ‘тооройн’ гэсэн хувилбар байж болохоор.

²⁵ Schuessler A. Minimal Old Chinese and Later Han Chinese. A Companion to *Grammata Serica Recensa*. Honolulu, University of Hawai'i Press, 2009, бичвэрт Minimal Old Chinese гэж товчилж хэрэглэнэ.

²⁶ Холдоо өртөө хэр газар зайтай харагдсан.

²⁷ Цэвээндорж Д., Батсайхан З., Төрбат Ц. Сүннүгийн хот суурины асуудал – ШУАМ. № 3-4. УБ., 1994, т. 77-85; дахин хэвлэл – З.Батсайхан. Хүннүгийн түүх, археологийн судлал – Бүтээл туурвилын эмхэтгэл. I боть. Эрхэлсэн Д.Заяабаатар. Эмхэтгэсэн Ч.Амартүвшин, У.Эрдэнэбат, Ц.Төрбат. УБ., 2022, т. 381-388

Бэхлэлт хаана байгааг эрж хайхын өмнө хэн түүнийг барьж байгуулсныг авч үзье. М.э.ө. 127 оноос өмнө Хүннү гүрний харьяанд байсан *лоуфань* юм уу *линьху* аймгийн язгууртан болох Чжаосинь м.э.ө. 131 оны 8-р сараас өмнө Хань улсад дагаар орж, 8/9-р сарын заагт ханьгийн хааны ордноос *хоу* хэргэм хүртэж, эзэмшил газартай болжээ. Гэвч м.э.ө. 123 оны зун болсон байлдаанд олзлогдож, шаньюйд шадарлаж, цэргийн хэрэг бодлогод нь зөвлөж, арван хэдэн жил болоод м.э.ө. 108 онд үхжээ. Түүнийг олзолсон Ичжисе шаньюй (м.э.ө. 126-114, 伊稚斜, yizhixie) Чжаосинь-д *цзыцы* (自次, zici) ван гэсэн цол өгсөн гэж В.С.Таскин орчуулсан мэдээг Энно Гил, шаньюй зөвхөн өөрийнхөө дараа орох эрх мэдэлтэй нэгэн болгосон гэж орчуулсан.

Бэхлэлтэд холбогдох баримтыг «Түүхийн тэмдэглэл», «Хань улсын бичгийн» Хүннүгийн бүлэг болон Вэй Циний намтрыг орчуулсан В.С.Таскин, А.Р.Вяткин, Энно Гил, Ж.Майкл Фармер, Жозеф Яп нарын орчуулгаар²⁸ толилуулъя.

Хань улсын хаан м.э.ө. 119 оны хавар (2.9–5.7) их жанжин Вэй Цинд 50000 морьт цэрэг хэдэн зуун мянган явган цэрэг²⁹ өгч Хүннүг довтол гэж тушаажээ. Олзлогдсон хүннү хүнээс шаньюй зүүн тийш явсан гэх мэдээлэл авсан ханьгийн цэрэг хоёр замаар довтлохоор болж, анх төлөвлөснөө өөрчлөв. Динсян хотоос мордсон их жанжин Вэй Циний армийн манлайг Ли Гуан³⁰, зүүн гарын цэргийг Гунсунь Хэ, баруун гарын цэргийг *чжуцзюэ түшмэл* Чжао Ицзи, арын хамгаалалтын ангийг *пинъян хоу* Цао Сян нар тус тус захирчээ. Вэй Цин армия хоёр хувааж, зүүн замд Ли Гуан, Чжао Ицзи-ийн хоёр нэгтгэлийг хуваарилав. Вэй Циний захирсан баруун замын цэрэгт Гунсунь Хэгийн зүүн гар, Цао Сяны арьергардын ангиуд хамт явжээ. Дөчөөд мянган морьт цэрэгтэй, гурван хэсгээс

²⁸ Таскин В.С. Материалы по истории сюнну (по китайским источникам). Предисловие, перевод и примечания. Москва, Издательство «Наука», ГРВЛ., 1968, стр. 54-55, 90-91; Сыма Цянь. Исторические записки (Ши цзи). Том IX. Перевод с китайского, комментарий под редакцией А.Р.Вяткина. Вступительная статья А.Р.Вяткина. Москва, «Восточная литература» РАН., 2010, стр. 36-38; The Hsiung-nu, Memoir 50. Translated by Enno Giele – The Grand Scribe's Records. Volume IX. The Memoirs of Han China, Part II by Ssu-ma Ch'ien. Edited by William H.Nienhauser, Jr. Bloomington, Indiana University Press, Nanjing, Nanjing University Press, 2011/2019, pp. 289-290; General Wei and [General of] Agile Cavalry, Memoir 51. Translated by J.Michael Farmer – The Grand Scribe's Records. Volume IX. The Memoirs of Han China, Part II by Ssu-ma Ch'ien. Edited by William H.Nienhauser, Jr. Bloomington, Indiana University Press, Nanjing, Nanjing University Press, 2011/2019, pp. 335-337; Yap, Joseph P. The Western Regions, Xiongnu and Han. A Collection of Chapters from the Shiji, Hanshu and Houhanshu. Translated and annotated. 2019, pp. 76-78, 317

²⁹ Вэй Цин, Хо Кюйбин нарт тус бүрд нь 50 мянган морьт цэрэг захируулжээ. Их цэрэг хуралдуулсан учир асар их хоол хүнс ачиж тээвэрлэх болжээ. Ачаа тээвэрлэх цэргийн агт дутагдсан тул ард иргэдийн 140 мянган морийг цэргийн хэрэгт дайчилж татсан гэхээр ямар их хүчээр Хүннүг түрэмгийлсэн нь төсөөлөгдөх байх. Түүнчлэн, явган цэрэг болон ачаа хөсөг зөөвөрлөхөд туслах ажилчид нийлээд хэдэн зуун мянган хүн болсон гэдэг (Yap, Joseph P. The Western Regions, Xiongnu and Han. A Collection of Chapters from the Shiji, Hanshu and Houhanshu. Translated and annotated. 2019, p. 77).

³⁰ М.э.ө. 166 онд анх *хүннү* нартай нүүр тулж тулалдаж эхэлсэн Лунси нутгийн хүмүүн Ли Гуан (李廣, li guang) жар гарсан хойноо м.э.ө. 119 оны хавар болсон Хүннүг түрэмгийлсэн аян дайнд оролцжээ. Манлай цэргийн захирагч байсан хэдий ч Вэй Цин-ий тушаалаар гол чиглэлээс зайлуулагдан, зүүн замын цэрэгт хуваарилагджээ. Мэдэхгүй замаар замчгүй явж төөрсөн гэдэг. Хэрэг тохож шийтгэх гэхэд нь амиа хорложээ.

бүрдсэн Вэй Циний баруун замын цэрэг мянган ли зам туулаад тэднийг хүлээж байсан шаньюитай таарав. Хүннүгийн цэрэг тэднийг хүлээж, ‘байр’ эзэлж жагссаныг харсан Вэй Цин их жанжин дээрээсээ, бөөрнөөсөө хамгаалж хуягласан байлдааны тэргүүдээ тойруулан байрлуулж шивээлжээ. Ингэж байрлах зуураа таван мянган морьт цэргээр шаньюйг дайрав. Хүннү хэдэн цэргээр Вэй Цинтэй байлдсаныг ханьгийн сударчид орхигдуулсан ч яг энд болохоор арваад мянган *хүннү* цэрэг довтолсон таван мянган *хань* цэргийг тосож хатгалдсан гэжээ. Нар шингэх үед нүүр нүдгүй шороо шуурч талууд бие биеэ харахаа больжээ. Харанхуйлж шуурахыг Вэй Цин ашиглаж зүүн, баруун жигүүрийг хөдөлгөж хажуу бөөрнөөс нь хумьж давшсаар *хүннүчүүдийг* бүсэлжээ. Дайсны тоо гурав/дөрөв дахин ихийн дээр, хүн морь нь сульдаагүй хүч тамир хэвээр байгааг мэдсэн Ичжисе шаньюй зууралдан байлдаад ч тусыг олохгүйг ухаарч, 6 луус хөллөсөн тэргэндээ сууж турхаг цэргээ³¹ дагуулж, ханьгийн бүслэлтийг шувталж дайраад баруун хойшоо ухасхийв.

Тулалдааны талбарт холилдож хутгалдсан *хүннү*, *хань* цэргүүд харанхуй болсон ч харилцан алалдаж, цавчилдсаар, ижил тооны хохирол амссан гэж ханьгийн сударчид тэмдэглэсэн байдаг. Зүүн жигүүрт тулалдсан ханьгийн бага тушаалын жанжин олзолсон *хүннү* хүнээс шаньюй байлдаж эхлэхэд л тулалдааны талбарыг орхин одсоныг сонсож мэдээд дээш айлтгахад шөнө болчихсон байжээ. Дайснаа алдахыг үл хүссэн Вэй Цин эхэлж хөнгөн зэвсэглэсэн морьт цэрэг илгээж мөр хайлгаад, удалгүй өөрөө их цэргээ дагуулан шаньюйг мөшгөжээ. Ханьгийн цэргийн зонхи олонх шаньюйг мөшгөхөөр одож, тулалдагч *хань* цэргийн тоо цөөрснийг гадарласан *хүннүчүүд* тулалдааны талбарыг гэнэт орхицгоож, цацсан од мэт тарж бутран бараа сураггүй алга болов.

Шаньюйг хөөсөн ханьгийн цэрэг үүр цайж гэгээ ортол мөшгөж 200 ли газар хороосон ч түүний барааг ч олж харсангүй. Харин Дяньянь (寔顔, dianyan) уулын дэргэд байрлах Чжаосинь бэхлэлт хүрчээ. Ханьгийн цэрэг бэхлэлтэд агуулж хураасан гурил будаагаар хооллож өдөр өнгөрөөгөөд буцахдаа үлдсэн гурил будааг шатааж устгав.

Үүний дараа Вэй Циний корпус шууд буцаж говь давж өмнө захад нь хүрчээ. Тэнд тэд нараас тусдаа зүүн замаар давшиж байгаад төөрч будилсан Ли Гуан жанжин, Чжао Ицзи жанжны хоёр ангитай тааралдаж уулзав.

Чжаосинь бэхлэлтээс зүүн урд зүгт хоёр зуун ли (70-80 км) зайд, говийн умард захад болсон тулалдаанд хүннүгийн арван мянган³² хүнийг алж, олзолсон гэж ханьгийн бичгийн хүмүүс бичиж үлдээжээ. Харин ханьгийн нэрт жанжин цэргийнхээ хорин таваас–гучин хувийг алдсан болов уу.

³¹ Нэг овог буюу хүрээ хэрийн цэрэг байсан байх, өөрөөр хэлбэл 500-600 цэрэг гэсэн үг.

³² Тулалдаанд оролцсон хүннүгийн цэргийн тоо нь алагдаж, олзлогдсон цэргийн тоотой ижил байгаа нь анхаарал татаж байна. Ханьгийн цэрэг хорин тав/гуч орчим хувийн хохирол амссан гэдэг дүгнэлтийг хүннү, ханьгийн цэрэг тулалдаанд ижил тооны цэргээ алдсан гэх баримтад тулгуурлаж тооцооллоо. Харин тулалдаан эхэнд *хүннүчүүд* яг хэдэн цэрэгтэй байсныг хэлж мэдэхгүй байна. Ханьгийн бичгийн хүмүүсийн тэмдэглэснээр бол Вэй Цинтэй эхэлж байлдахдаа лав арваад мянган цэргээр давшсан байдаг.

М.э.ө. 90 оны хаврын гурван сард (4.17–5.16) далан мянган цэрэг захирсан Ли Гуанли жанжин Уюань хотоос мордож Хүннүг довтолсон. Тэгэхэд Хулугу шаньюй Чжаосинь бэхлэлтээс ачаа бараа, тэргээ Чжигюй шуй руу татсан гэж сурвалжид тэмдэглэсэн баримт бол Чжаосинь бэхлэлт байж болох газрын чигийг заасан хоёрдох чухал мэдээ болно.

Тэгэхээр Чжаосинийг хайхад Динсян, Уюань гэсэн хоёр хотын байрлал тун чухал аж.

Вэй Цин жанжин Динсян хотоос мордсон билээ. БНХАУ-ын эрдэмтэд Динсян хотыг Хөх хотын бараг чанх урд 36-37 км-т, Хорингэр хотоос баруун хойш 12-13 км-т 111°42' уртрагт байснаар зуржээ. Нөгөө Уюань хотыг одоогийн Бугат хотын баруун талд хориод км-т байсан гэж үзжээ.³³

Динсян, Уюань хотын байрлалыг харгалзвал ханьгийн цэрэг Өмнөговь аймгийн нутаг хүртэл давшсан нь эргэлзээтэй үзэл баримтлал болох нь.

Тиймээс Чжаосинь бэхлэлтийг Дорноговийн нутгаас эрж хайж эхэлсэн билээ. Өнөөдөр мэдэгдэж байгаа, судалгааны эргэлтэд орсон том жижиг байгууламжийн байрлалыг шалгасаар Хатанбулаг сумын Хатны булгийн өмнө ба зүүн, зүүн хойд чигт байдаг байгууламжууд дээр анхаарлаа төвлөрүүлж³⁴, сонирхож эхэлсэн.

Хүннүтэй олон удаа байлдсан харийнхны түүхэнд үлдсэн мэдээгээр бол тус бэхлэлтийг м.э.ө. 122-119 оны хооронд байгуулж гуч-дөчин жил ашиглаж. Гол нь энд олон хүн байнга сууж байгаагүй гэж бодож байна. Бусад газраас авчирч түр хугацаагаар хадгалдаг хүнсний нөөц болон бараа таваар хардаг цөөн тооны харуул сууж байсан гэмээр. Тиймээс цэрэг дайны бэхлэлт байж болох ч бас хоол хүнсний хангалтын бааз болгож ашигладаг байгууламжийн шинж бүрэн давамгайлсан бэсрэг байгууламж ч байж мэдэх юм, анхааралгүй орхиж болохгүй байх. Ялангуяа м.э.ө. 90 оны мэдээг үндэслэвэл дэвшүүлж байгаа таамаглал маань боломжийн. Ингэж үзэх бас нэг үндэслэл бол Вэй Цин жанжны захирсан гуч-дөчин мянган хүнтэй ханьгийн корпусын туулсан зам, чиглэл, зай юм. Тэрээр одоогийн Хорингэр хотын ард байсан хотоос гарч Иньшань уул, уулын ар хормойгоор үргэлжлэх бэхлэлт хэрмийг давж шаньюйтай таартлаа мянган ли явсан. Тэр үеийн нэг ли-г эрдэмтэд 414 метр байсан гэж тогтоосон. Гэвч ханьгийн

³³ Хятадын түүхийн атлас. II боть. Цинь-Ханьгийн үе. Ерөнхий ред. Тань Цисян. Бээжин, ХГЗХГ., 1996, т. 17-18, 2х9, 2х7 (хятадаар)

³⁴ Хатны булгийг 2016-2018 онд ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн Эртний түүхийн салбарын судлаачид бусад байгууллагын судлаачидтай хамтарч малтаж судалсан бөгөөд 2022 онд «Домогт Хатны булаг» гэсэн бүтээлээ хэвлэж олон нийтэд толилуулсан. С.Өлзийбаяр, Б.Баатархүү нарын судлаач Хатны булаг орчмын байгууламжуудыг галт зэвсэг хэрэглэх болсон үеийн хамгаалалт бэхлэлтүүд гэж үзжээ (Өлзийбаяр С., Баатархүү Б., Очир Б., Уранжаргал А. Домогт Хатны булаг. Линограф ХХК., Улаанбаатар, 2022).

Хүннүгийн дайн байлдаан болсон газар орныг эрж хайх явцад Дорноговь аймгийн өмнөд хэсэгт анхаарлаа хандуулж эхэлсэн. Ялангуяа 2016 онд хэвлүүлсэн «Ухуань (Авар) ба Сяньби (Сэрби)» зохиолоо бичих үеэр Хо Кюйбиний туулсан замыг нэмж нягтлан, тодруулах явцад Баянбулагийн турь нь Чжаосинь бэхлэлт байх боломжгүй нь тодорхой болсон. Хатны булгийн хоёрдох удаагийн малтлагад оролцож ажиллаж байхдаа эл санаа маань улам гүнзгийрч, шинээр бодож боловсруулсан санаагаа дахин нягталж, тооцоо, маршрутаа ахин дахин шалгах болсон.

цэргийн Хүннүг уулгалан түрэмгийлсэн олон удаагийн довтолгоог баримтад үндэслэж хэмжихэд лав говь давж Хүннүг дайрах ханьгийн цэргийн туулсан замыг тооцоолохдоо нэг ли-г 414 метрээр авч болохгүй нь илэрсэн. Тэгвэл нэг ли нь хэдэн метр вэ? гэж асуувал ойролцоогоор 390/400 орчим метрийг нэг ли гэж болно хэмээн хариулна.

Тэгэхээр, м.э.ө. 119 оны дундуур Динсянаас гарсан Вэй Циний цэрэг 400-аад км зам туулаад Ичжисе шаньюйн цэрэгтэй таарчээ гэж багцаалж болно. Таамгаар маань бол хуучин Сулинхээрт³⁵ Ичжисе шаньюй Вэй Циний цэрэгтэй байлдаад ялагдаж баруун хойш зугтахад мөшгөсөн Хань улсын цэрэг тэндээс 75-80 км зайтай Хатны булагт байсан Чжаосинь бэхлэлт хүрч, өдөр өнгөрөөж, үр тариаг л шатаагаад³⁶ буцжээ.

Харин Ли Гуанли жанжны цэрэг м.э.ө. 90 онд Хүннүгийн нутагт нэвтрэнгүүт хүннүчүүд довтолгооных нь чиглэлд/замд нь байсан бэхлэлт-хэрмээсээ хоол хүнсний нөөц, ачаа тээврийн хэрэгслээ үтэр түргэн татаж авчээ.

Хатны булгийн хэрэм Чжаосинь бэхлэлт биш ч байж мэднэ. Харин бидний санал болгож байгаа чиглэл хөдөлгөөнгүй. Бас хуучин байгууламжийн ор дээр шинэ байгууламж барьж босгох уламжлал манай энэ хавиар нэг түгээмэл байсныг сануулах нь илүүц биз.

Чжигюй. Эрши хэмээн алдаршсан Хань улсын Ли Гуанли жанжин Чжигюй хүрээгүй гэдгийг түүхэн баримт нотолдог ч тэр газар хаана байсныг тогтоох шууд баримт байхгүй. Иймээс эхлээд, Чжигюй-г хайх үндэс болсон дам мэдээтэй баримтын³⁷ В.С.Таскин, Жозеф Яп нарын орчуулгыг харна уу.

Таскин – *Шаньюй, узнав, что крупные силы ханьских войск выступили в поход, отправил все обозы к северу от города Чжао-синь на берега р. Чжицзюй.*

Жозеф Яп – *When the Chanyu heard of the approaching Han armies, he ordered their baggage trains and belongings to move to the Zhiju River, north of the Zhao Xin Fort.*

Хань улсын бичгийн 94-р бүлгийн 3778-д байдаг, орос англи орчуулгыг нь харуулсан мэдээг “Ханьгийн их цэрэг гарсныг сонссон шаньюй бүх ачаатай тэргээ Чжаосинь бэхлэлтээс умард зүгт байдаг Чжигюй усны орд (邸, di)³⁸

³⁵ XIX зууны эхэн хагасын сүүлээр байгуулсан Задгай хийд орчим гэсэн үг.

³⁶ В.С.Таскин “пробыв здесь один день, [Вэй Цин] сжег имевшиеся в городе остатки зерна и выступил в обратный путь” гэж, Ж.Майкл Фармер “the army stayed for a day and then went back, burning the remaining grain in the walled-city upon their return” хэмээн орчуулсан бол Жозеф Яп “the army stayed in the Fort for one day and retreated, they then set fire to the stored grain” гэж хөрвүүлжээ. Лав энэ гурван орчуулгаар бол Чжаосинийг галдаагүй ба зөвхөн нөөц хүнсний үр тариаг шатаасан мэт.

³⁷ 單于聞漢兵大出，悉遣其輜重，徙趙信城北邸鄣居水。

³⁸ Эдвин Пуллиблэнкийн 1991 оны «Lexicon of Reconstructed Pronunciation in Early Middle Chinese, Late Middle Chinese, and Early Mandarin» гэдэг сэргээлтийн толь бичигт *ди* (邸) гэдэг үгийг ‘residence of a prince’ (p. 76) гэж англи руу буулгажээ. Тиймээс бид *ди чжигюй шуй* (邸鄣居水, di zhiju shui)-г Чжигюй усны орд гэлээ.

руу явуулав” гэж найруулж хөрвүүлмээр аядлаа. Чжигюй шуй нь Чжаосинь бэхлэлтээс хойно байсан нь тодорхой харагдана. Бас Чжигюй (鄧居) гэсэн нэрд дагалдуулсан ‘шуй’-г гол мөрөн гэлгүй ‘ус’ гэлээ. Монголын нууц товчоонд Сохог ус (Soqoγ Usun, § 158), Нэгүн ус (Nekün Usun, § 188) гэж гардаг, тэдэн лугаа адил юм байна гэж үзэх болоод удаж байгаа билээ. Өөрөөр хэлбэл, Чжигюй шуй-г Сэлэнгэ мөрөн эсвэл Туул гол гэж оноосон гадаадын эрдэмтэд, тэднийг дагасан дотоодын эрдэмтэд алджээ.

Чжигюй/Чжицзюй-н сэргээлт:

EMC	teit.kiə	(Lexicon of Reconstructed, 410, 162)
LH	*tsit.kia	(Minimal Old Chinese, 29-15, 1-1)
BX	*cət.ka	(Китайские иероглифы, 1956, 356)
ЗХ	*tjət.ka	(Китайские иероглифы, 1956, 356)

Э.Пуллиблэнк³⁹, А.Шюсслер, С.А.Старостин⁴⁰ нарын сэргээлт кириллээр – *цагаан*, *цэгээн* гэж бичдэг, харин уйгуржин монголоор бол – ‘caγan’, ‘cāgān’, ‘cegen’ гэж бичдэг үгтэй адилхан харагдаж байна. Ийм нэртэй том бага нуурууд олон байдаг. Жишээ гэхэд Дундговь аймгийн Цагаандэлгэр сум, Төв аймгийн Баянцагаан сумын нутагт хоорондоо 18 орчим км зайтай Их Цэгээн, Бага Цэгээн гэсэн хоёр нуур байна. Бага Цэгээний зүүн хойхон талд өртөө газарт хавьгүй том Умбийн Цагаан нуур гэж бас бий. Байр зүйн зургаар бол тэр хавийн нутагт янз бүрийн хэмжээтэй нуур тойром олон байх аж.

Чжигюй ус (Чжицзюй шуй/zhiju shui) энэ хавьд байх боломжтой, ялангуяа Их, Бага Цэгээн нуурыг онцольё. Эндээс баруун хойш гуч, дөчин километрт м.э.ө. II зууны сүүл хагасаас м.э.ө. I зууны эхэн хагаст холбогдох хүннүгийн үеийн томоохон бүлэг дурсгал⁴¹ Чихэртийн зоо-д байсныг илрүүлж, малтаж судалсан ба тэрэг олдсон.

М.э.ө. 90 оны Гуцзюйшуй. М.э.ө. 90 оны хаврын гурван сард (4.17–5.16) эхэлсэн дайны тухай бичвэрт дурдсан Гуцзюй (姑且, guju) шуй (水, shui)-аас гадна ханьгийн бичээчид м.э.ө. 58 оны хүннүгийн иргэний дайныг тоймлохдоо бас нэг Гуцзюй шуй-г тэмдэглэжээ. Тэмдэглэсэн үсэг нэг тул нэг газар гэж эндүүрэх магадлалтай. Гэвч бичвэрийг сайтар харвал хоёр өөр газар гэдэг нь шууд мэдэгдэх юм шиг санагддаг.

– Чжаосинь бэхлэлтээс ачаа бараа, хөсөг тэргээ зөөж Чжигюй усны ордод авчирсан таталт бол өмнөөс хойшоо гэсэн чиглэлээр явагдсан тээвэрлэлт. Дашрамд дурдахад м.э.ө. 119 онд Чжаосиньд нөөцөлсөн үр тариа, хүнсээ зөөж чадалгүй шатаалгасан гашуун сургамжийг *хүннүчүүд* мартаагүй бололтой. Иймээс 29 жилийн дараа Хань улс дахиж түрэмгийлэхэд авсан эн тэргүүний арга хэмжээ бол Чжаосиньд байсан

³⁹ Pulleyblank, Edwin G. Lexicon of Reconstructed Pronunciation in Early Middle Chinese, Late Middle Chinese, and Early Mandarin. Vancouver, The University of British Columbia, хойш Lexicon of Reconstructed гэж товчилж эшилнэ.

⁴⁰ Китайские иероглифы. Составитель: Старостин С.А. цахим PDF толь, хойшид Китайские иероглифы гэж товчилно.

⁴¹ Эрэгзэн Г., Энхболд С., Алдармөнх П., Чу Санги, У Жэ жин, Им Дунжэ, Ан Жэпил. Чихэртийн зоо ба Баянцагааны дурсгал. УБ., 2020

бүхнээ аюулгүй газарт зөөсөн үйлдэл байжээ. Үүний дараа Хулугу шаньюй Ли Гуанлийг нэхэхдээ хойноос урагшаа чигтэй элджээ. Тэгэхээр ачаа бараагаа татаж, дайснаа нэхэж хөөсөн хоёр үйлдэл хоёул уртрагийн чиглэлтэй болжээ.

– Шаньюй болоод хүннүгийн зүүн гарын түмтүүдээс 4 эсвэл 5 түмт цэрэг татаж, хүннүгийн баруун гарын түмтүүдийг түшиж тулах бодлого барьж байсан Уяньгюйди шаньюйг (м.э.ө. 60-58) довтлохдоо Хуханье (м.э.ө. 58-31)-гийн хүрсэн Гуцзюй шуй, Хулугу шаньюй (м.э.ө. 96-85) дайрч өнгөрсөн Гуцзюй шуй хоёр өөр газар гэдгийг дахин хэлье. Өөрөөр хэлбэл, м.э.ө. 90 оны улсаа хамгаалах дайнаас 42/43 жилийн дараа болсон эрх мэдэл булаалдсан иргэний дайнаар нэр нь гардаг Гуцзюй шуй бол өргөргийн чиглэлд болсон Хуханьегийн довтолгоо зогссон газар юм. Өөрөөр хэлбэл, Хуханье шаньюй нь Улаанбаатарын зүүн талд байдаг газраас нийслэлийн баруун талд орших газарт хүрсэн гэсэн үг. Дахиж тайлбарлах тул м.э.ө. 58 оны Гуцзюй шуйг түр орхиж м.э.ө. 90 оны улсаа хамгаалах дайнаар нэр гарсан Гуцзюй хаана байгааг эрж хайя.

Холбогдох мэдээг эрдэмтэд янз бүр орчуулжээ. Н.Я.Бичурин (Иакинф), А.Вайли/Уайли, Э.Паркер, Ян Якоб Мария де Грот⁴², В.С.Таскин, Жозеф Яп нарын орчуулгыг харьцуулна уу.

Бичурин – *Шаньюй принял начальство над отборным войском. Восточный Аньхоу перешел за реку Гуцзюй.*

Вайли/Уайли – *The Shen-yu took command of the elite of the troops in person. The Left Ganhow crossed the Koo-tsey river.*

Паркер – *The Khan personally led his best troops. The Left An Marquess crossed the River Ku-tsü.*

де Грот – *Der Tan-hu, der persönlich an der Spitze der Kerntruppen am linken An-hö (Orchon) stand, überschritt den Kō-tsu Fluß (Kodasun?).*

Таскин – *Шаньюй, возглавил отборные войёка, оставил слева [реку] Аньхоу и переправился через реку Гуцзюй.*

Жозеф Яп – *The Chanyu and Left Marquis An then led their elite troops to cross the Guqie River.*

Хань улсын бичигт байгаа «shan-yu zi jiang jing bing zuo-an-hou du gu-ju-shui/單于自將精兵左安侯度姑且水» гэх мөрийг 1851-2019 оны хооронд эрдэмтэд 6 удаа орчуулахдаа гурван өөр уншжээ. Я.Я.М. де Грот, В.С.Таскин хоёроос бусад нь «zuo-an-hou/左安侯» гэх үгийг «зүүн Ан гүн» гэж цол хэргэмтэй ноён болгож орчуулжээ. Де Грот болохоор, Аньхоугийн зүүн талд цэргээ зассан данху (шаньюй) Коцу голыг дайрч ирсэн гээд Аньхоу-г Орхон гол, Коцу-г Кодасун гол

⁴² Өмнө нь В.С.Таскин, Жозеф П.Яп нарын орчуулгыг эшлэхдээ бичсэн учир энэ удаа Бичурин, Вайли/Уайли, Паркер, де Грот нарын бүтээлийг дурдъя.

Бичурин Н.Я. Собрание сведений о народах, обитавших в Средней Азии в древние времена. Том I. Москва-Ленинград, Издательство Академии Наук СССР, 1950, стр. 75; Wylie A. History of the Heung-noo in their Relations with China. Translated from the Tseen-Han-shoo. Book 94 – The Journal of the Anthropological Institute of Great Britain and Ireland. Vol. III. London, Trübner & Co., 57 & 59, Ludgate Hill, 1874, pp. 438-439; Parker E.H. The Turko-Scythian Tribes (Continued from Vol. XX, No. 1, p. 24) – The China Review. Vol. XX, No. 2. 1892, p. 114; de Groot J.J.M. Die Hunnen der vorchristlichen zeit. Chinesische Urkunden zur Geschichte Asiens. Erster Teil. Übersetzt und Erläutert. Berlin und Leipzig, Vereinigung Wissenschaftlicher Verleger, Walter de Gruyter & Co., 1924, S. 178

гэжээ. Харин В.С.Таскин, шилдэг цэргээ захирсан шаньюй ханьгийн цэргийг гүйцэхээр довтолгох үедээ зүүн талдаа Аньхоуг орхиж урагшилж явахдаа Гуцзюй голыг гаталж дайснаа нэхжээ гэж ухахаар буулгажээ.

Энэ зурвас мэдээг яаж буулгаж, ойлгох нь юуны өмнө тэр цагт болж өнгөрсөн хоёр өөр хэрэг явдлын холбоос уу? үгүй юу гэдгээс хамааралтай мэт. Тэгээд өнөөдрийн хувьд – *нэг*, Чжаосиниэс ачаа, тэргээ Чжигюй усны ордод зөөсөн, *хоёр*, Чжигюй усны ордыг чиглэж давшаад буцаж ухарсан ханьгийн цэргийг Суюяньжань ууланд буухад нь *хүннүчүүд* гүйцэж бүсэлсэн гэсэн хоёр үйл явдлыг холбох, дунд нь болсон хэрэг гэж тайлбарлав.

Гуцзюй шуй-г хайхдаа Чжаосинь ба Чжигюй усны, өөрсдийн тогтоосон байршлыг ашиглана. Дашрамд хэлэхэд, эл гурван байрлалын нэгийг л тэс өөр газарт найдвартай тогтооход л үлдсэн хоёрын байршил ч бас дагалдаад бишдэх юм. Хоорондоо холбоотой нь түүхэн баримтаа гүйлгэлгүй уншихад илэрхий харагддаг. Тиймээс нэг гагнаастай оноолтууд болж байгаа юм.

Гуцзюй-гийн сэргээлт:

EMC	kə.tsia	(Lexicon of Reconstructed, 110, 162)
LN	*ka.tsia	(Minimal Old Chinese, 1-1, 1-57)
ЗХ	*kā.chiá	(Китайские иероглифы, 347, 82)
ОСМ	*kâ.tsa.	(Minimal Old Chinese, 1-1, 1-57)

Чжигюй ус шиг нуур байж магад, бас сэргээлтээ харгалзвал Дундговь аймгийн Өндөршил сумын Өндөршил уулын баруун урдах хэдэн том нуурын⁴³ нэг Гашуун нуурыг Гуцзюй гэж үзсэн ба энэ хавийг бүхэлд нь Гуцзюй ус гэж нэрлэж байсан хэмээн таамаглалаа.

(Цзо)аньхоу. Тайлбарлахад хамгийн төвөгтэй бөгөөд эрдэмтэд газар усны нэр үү? эсвэл албан тушаал, хүний нэр үү? гэдгийг нь найдвартай ялгаагүй оноосон нэр гэдгийг л одоогоор сайн мэдэж байна. Тийм хэдий ч учрыг нь олох гэж оролдъё. Төвөгтэйн гол гогцоо нь «ань/ап» гэдэг утга үсгийн урд, хойно байгаа «цзо/зuo», «хоу/hou» гэсэн хоёр үсэгт байгаа юм. Эрдэмтэд энэ хоёрыг л янз бүрээр ухаж, нэг бол зүүн гарын Ань гүн гэж, эсвэл Аньхоугийн зүүн тал гэж, эсвэл бүр *хүннүчүүд* урагшлахад зүүн талд нь Аньхоу гэдэг гол байжээ, түүний дэргэдүүр өнгөрч явжээ гэж ойлгохоор орчуулжээ. Дагалдаад олон янзын тайлбар гарах нь мэдээж. Тухайлбал, албан тушаал гэвэл, шилдэг цэргээ биечлэн захирсан шаньюйтай, зүүн гарын хоу Ань гэгч Гуцзюй шуйг дайрч очоод нэгдсэн гэмээр. Ийм бол Гуцзюйг олоход л хангалттай, илүү ажил хийх шаардлагагүй гэсэн үг. Гэтэл ийм цол Хүннүд байсан эсэх нь тун эргэлзээтэй, бараг л байхгүй дээ. Бас Аньхоуг Орхон гол гэж олон судлаач шууд л хэлнэ, уламжлалт үзэл баримтлал. Ингэвэл лав В.С.Таскиний орчуулга ямар ч утгагүй болчихно. Яагаад гэвэл, зүүн талдаа Орхоныг өнгөрөөнө гэхээр хүннүгийн тэр их цэрэг Хангайн нурууг хамгийн бэрх хэсгээр давах хэрэгтэй. Ер нь Орхоныг гаталж байж л сая говь руу довтолгох бус уу. Голланд эрдэмтэн де Гротыг дагавал Орхоны зүүн талд

⁴³ Байр зүйн зургаар бол – Зүүн Гялгар (Гялаан?), Хөндлөнгийн Гялаан, Гашуун

цэргээ зассан шаньюй Кодасун голыг дайрч ханьгийн цэргийг гүйцжээ. Харин бид Аньхоу бол Орхон биш гэдгийг хангалттай нотолж чадсан гэж бодож байгаа. Гол нь Хань улсын түрэмгийлэгчдийн мордсон чиглэл, явсан замтай Орхоны хувилбар ер авцалдахгүй.

Ингэхлээр олон хувилбараар авч үзэхээс өөр сайн арга бидэнд үлдсэнгүй. Юуны өмнө уг үгийг газрын нэр гэж үзэх нь *хоу цолтой ноён* болгосноос хамаагүй боломжтой шийдэл гэж бодож байна. Харин «Зүүн Аньхоу» гэх үү эсвэл «Аньхоугийн зүүн» гэх үү эсвэл бүр өөр хувилбар (?) байгаа юу гэдгийг шийдэх шаардлагатай. ‘Цзо-ань-хоу’ гэсэн 3 үсгийг нэг үг болгож унших хувилбар байна. Тэгвэл – шаньюй шилдэг цэргээ Цзоаньхоу-д засаж, биечлэн захирч мордоод Гуцзюй шуйг дайрч ирсэн гэж ойлгохоор орчуулж болмоор санагдлаа.

Цзоаньхоу/Zuoanhou-гийн сэргээлт:

EMC	tsa'.ʔan.ɣəw	(Lexicon of Reconstructed, 424, 24, 125)
СК	cā.ʔān.ɣlw	(Китайские иероглифы, 111, 171, 457)
BX	*cā.ʔān.gwā	(Китайские иероглифы, 111, 171, 457)
LN	*tsa.ʔan.go	(Minimal Old Chinese, 18-13, 24-11, 10-6)
ЗХ	*cāj.ʔān.gwā	(Китайские иероглифы, 111, 171, 457)

Сэргээлтээс харвал, одоо цагт *цзоаньхоу* гэж дуудаж байгаа галигт *čä.kär.gu гэж болох үг далдлагдсан юм шиг ээ. Монголын нууц товчооны §§ 61, 94, 142-д ‘ciqurqu/ciqurqu’ гэдэг газрын нэр гардаг. Бас орчин цагт бид нар ‘чихэр’ гэж бичиж байгаа үгтэй төстэй болоод явчихлаа, гэвч зөв эсэхийг хэл шинжээчид нэг мөр болгох буй заа.

Чжигюй шуйг хаана байсныг эрж байхдаа Чихэртийн зоо гэдэг газрыг дурдсан. Бас сурвалжид уг нэрийн урд ‘ханхүүгийн ордон’ гэж англи хэл рүү орчуулсан ‘ди’ гэсэн утга үсэг байдгийг ахиж үзүүлэе – «*ди* чжигюй шуй, 邸郵居水, di zhiju shui».

Чжаосинь бэхлэлт, Чжигюй ус, Гуцзюй усны судалгаа хийгээд Цзоаньхоу-г шинжлэхийг оролдсон судалгаагаа хялбаршуулсан жагсаалтаар харуулъя.

Фуянгоу уул	Иньшань (Даланхар) ууланд эрж хайх хэрэгтэй.
Фаньфужэнь	Хүннүгийн хот биш ажээ. Хань улсын умард хил дээрх олон бэхлэлтийн нэг бололтой, Даланхар уул – говийн заагт байгаа байх.
Чжаосинь чэн	Хатны булгийн хэдэн хэрмийн нэг нь.
Чжигюй ус	Дундговийн Цагаандэлгэр, Төв аймгийн Баянцагаан сумын нутаг дахь хоёр Цэгээн нуур.
Цзоаньхоу	Чжигюй усны орд гэж нэг газар өөрөөр дурдсан нүүдлийн ордын буусан газрын нэр. Чихургу/Чихэр гэсэн үгийн эртний үеийн хэлбэрийнх нь галиг. Төв аймгийн Баянцагаанд Чихэрт гэдэг газар байна.
Гуцзюй ус	Нэрийн сэргээлт үндэслэж байршлыг таамаглав. Гол нь Чжаосинь – Чжигюй хоёрын завсарт байх ёстой.

Дундговийн Өндөршил сумын Өндөршил
уулын баруугаар байгаа бүлэг нууртай газрыг
Гуцзюй ус гэж үзлээ. Тэдгээр нуурын нэгийг Гашуун гэнэ.

Жагсаалтад, 70 мянган хүнтэй ханьгийн арми бүрэн ялагдаж, бүтэн сүйрсэн газрын нэр ороогүй, түүнийг *Суеуяньжань* | *Сусеуяньжань уул* (Жозеф Ян, 2019 / В.С.Таскин, 1973) гэдэг. Юуны өмнө энэ уул бол Хожуу Хань улсын Доу Сянь жанжны очсон, хаданд нь бичиг сийлсэн Яньжань уулаас тэс өөр уул гэдгийг хэлье. Толилуулаад асар удаагүй бэсрэг судалгаагаар маань бол Чжаосинь бэхлэлт, Чжигюй ус хоёрын чигт, Динсян хот – Чжаосинь хотын завсарт, тэднийг холбох шугам дээр, эсвэл шугамд ойр байрлалтай газар ажээ. Энэ гурвыг харгалзаж байж олдоно.

Хүннүгийн газар усны байршлыг тогтооход хятад үсгийн эртний дуудлага сэргээсэн хэл шинжлэлийн судалгаа чухал хэрэгтэйг бид харсан. *Суеуяньжаний* эрэлд ч гэсэн дахиад сэргээлт ашиглая. *Суеуяньжань/Сусеуяньжань* (速邪烏燕然) *suiewuayanran/suxiewuayanran-ий сэргээлт*:

LN	*sok.ja.ʔa.ʔen.nan	(Minimal Old Chinese, 11-21, 1-47, 1-28, 23-15, 24-36)
BX	*sōk.zhā.ʔā.ʔjānh.nan	(Китайские иероглифы, 919, 304/574, 690, 1503, 1011)
3X	*sōk.lhia.ʔā.ʔiānh.nan	(Китайские иероглифы, 919, 304/574, 690, 1503, 1011)
OCM	*sōk.la.ʔā.ʔên.nan	(Minimal Old Chinese, 11-21, 1-47, 1-28, 23-15, 24-36)
OC	*slog.ljaa.qaa.qeen.njen	(Old Chinese Phonology, 470, 511, 491, 515, 450)

Сүүлийн хоёр нь кириллээр Сулинхээр гэж бичиж байгаа үгтэй дөхүү юм.

Газрын чиг баримжаа, зай, утга үсгийн сэргээлт гээд гарт байгаа ‘цөөхөн боломжоо’ ашиглавал *Суеуяньжань-ийг Сулинхээр гэж оноох саналтай байна.*

Юйу гол ба Доусянь уул. Хулугу шаньюй ачаа хөсгөө дайсны хөлөөс холдуулахтай зэрэгцээд зүүн сэцэн ван бас ард иргэдээ нүүлгэн шилжүүлжээ. Зүүн сэцэн вангийн харьяатууд Юйу голыг дайрч 600-700 ли (230-280/290 км) зайд байдаг Доусянь руу нүүжээ.

Юйу голыг олбол Доусянь уулын чиг баримжаа, бүр байршил нь ч олдох магадлалтай.

А.Г.Малавкин 1989 оны зохиолдоо, Юйу голын байршлыг тогтоосон ганц ажил байдаг. Хятадын судлаач Цзи Юн – Юйу голыг Онгийн (Вэнцзиньхэ, 翁金诃, wengjinhe) гол гэж үзсэн. Биднийхээр Юйу-г Онги гэх нь бодит байдалтай үл нийцэх оноолт болсон гээд холбогдох баримт мэдээ дурдаад, түүнээ үндэслэж “Юйу голыг Говиос өмнүүр, Хань улсын бэхлэлтэд ойр газар хайх хэрэгтэй” гэж үзсэн билээ.⁴⁴ Түүний саналыг дэмжиж байгаа ч Юйу нь ханьгийн бэхлэлт шугамд их ойр хайхаар гол биш гэсэн залруулга хийе.

Юйу голд хамаатай *эхний мэдээ* Хань улсын бичгийн хаадын бүлэгт бий. М.э.ө. 121 оны зуны тэмдэглэлд Юйу голд гүү унагалдаг⁴⁵ гэж бий. Хожуу Хань улсын сүүлээр амьдарч байсан Ин Шао (м.э. 144-204/207) Шофаны ард Юйу гол байдаг гэсэн тайлбар нэмсэн.

⁴⁴ Малавкин А.Г. Танские хроники о государствах Центральной Азии. Тексты и исследования. Новосибирск, «Наука», Сибирское отделение, 1989, стр. 132-133

⁴⁵ Түүхийн тэмдэглэлийн нэг газар Юйу голын адууг онцолсон байдаг.

Дараагийн хоёрдох мэдээ м.э.ө. 97 оны хаврын эхэнд холбогдоно. Жаран мянган морьт цэрэг, далан мянган явган цэрэг захирсан Ли Гуанли жанжин Шофанаас мордож Юйу голд хүннүгийн шаньюитай хэдэн өдөр ширүүн тулалджээ.⁴⁶ Хүннүгийн бүлэгт бүр тодорхой өгүүлэх ба Ли Гуанлигийн 130 мянган хүнтэй армид хатуу арбалетаар зэвсэглэсэн Лу Бодэ жанжны захирсан арван мянга илүү морьт цэрэг хүч нэмж, Хүннүтэй байлдсан. Үүнээс гадна 30 мянган явган цэрэгтэй Хань Юэ жанжин Уюань хотоос, 30 мянган явган цэрэг, 10 мянган морьт цэрэгтэй корпус захирсан *ицйой* хүн Гунсунь Ао, Яньмэниэс морджээ. Нийт 210 мянган хүнтэй ханьгийн их цэрэг гарсныг олж сонссон Жүтэгү (*Zütegeu*⁴⁷) шаньюй эд бараа, ард иргэдээ Юйу голоос хойшоо хол газар нүүлгэн шилжүүлж, өөрөө буман цэргээ удирдан, голын өмнө хүлээж байлдахаар зэхжээ. Арваад өдөр тулалдсаны дараа Ли Гуанли цэргээ хувааж бүлэглээд ухарсан юм.⁴⁸

М.э.ө. 90 оны гурван сард (4.17–5.16) дайсан ирэхийг сонссон зүүн *сэцэн ван* иргэдээ голоос хойших ууланд нүүлгэсэн гэх Юйу голд хамаатай *гурав дахь мэдээг* бид дээр дурдсан учир сануулаад орхиё.

Хүннүчүүд 9 мянган цэрэг илгээж Шоусян бэхлэлтийн дэргэд байрлуулж, ухрах болбол ашиглах гүүр Юйу гол дээр барьсан хэмээх м.э.ө. 79 оны үеийн мэдээ *дөрөв дэх* нь юм.

Юйу-ээс гадна Даньюйу гэдэг, мөн оросын судлаачид Сюйу гэсэн өөр хоёр гол байна.

Даньюйу, Сюйу голын талаар сүүлд өгүүлэх учир энэ удаа тайлбарлахгүй орхилоо. Харин одоо Юйу гэсэн хоёр үсгийг толь бичгүүдэд⁴⁹ яаж сэргээснийг харуулъя.

Юйу (余吾, yuwu)-гийн сэргээлт:

EH	*zah.ngâ	(Handbook of Eastern Han, Xu, 136, 137; Ying, 59)
LH	*ja.ŋa	(Minimal Old Chinese, 1-42, 1-29)
BX	*za.ŋhā	(Китайские иероглифы, 216, 226)

⁴⁶ Бань Гу. Хань шу («История Хань»). Том 1. Хроники правления императоров (Ди цзи). Перевод с китайского В.В.Башкеева, под редакцией М.Ю.Ульянова, комментарий, вступительные статьи и приложения В.В.Башкеева, М.Ю.Ульянова. Москва, ИДВ РАН., Вост. лит., 2021, стр. 224, 241; Малявкин А.Г. Танские хроники о государствах Центральной Азии. Тексты и исследования. Новосибирск, «Наука», Сибирское отделение, 1989, стр. 132

⁴⁷ Цзюйдихэу гэж Н.Я.Бичурин бичсэн, Четэхоу (Tseay-te-how) гэж А.Вайли/Уайли уншсан, Ц.Доржсүрэн болохоор Зүйдихү гэсэн шаньюйг Чүтихоу/Chütihou гэж буулгасан Э.Паркер уул үг нь Жүтэгү (Parker E.H. A Thousand Years of the Tartars. Second edition, revised and reset. London, New York, Kegan Paul, Trench, Trubner & Co., Ltd, Alfred A.Knopf, Inc., 1924, p. 30) гэж үзжээ.

⁴⁸ Таскин В.С. Материалы по истории сюнну (по китайским источникам). Выпуск второй. Предисловие, перевод и примечания. Москва, Издательство «Наука», ГРВЛ, 1973, стр. 19

⁴⁹ South Coblin W. A Handbook of Eastern Han Sound Glosses. Hong Kong, The Chinese University Press, 1983, хойш Handbook of Eastern Han гэж товчилж заана; Schuessler A. Minimal Old Chinese and Later Han Chinese. A Companion to *Grammata Serica Recensa*. Honolulu, University of Hawai'i Press, 2009; Китайские иероглифы. Составитель: Старостин С.А. цахим PDF толь

Дуудлага сэргээсэн 3 толиор бол Юйу гэсэн хоёр үсгийг зүүн/хожуу ханьгийн үед *za.ngâ ~ *ja.ŋa ~ *za.ŋa гэж хэлдэг байжээ. Кириллээр ‘заг’ (*jaŋ/jaγ) гэж бичиж үг харагддаг. Хөрхийн нурууны урд үзүүр Хотийн уул, Амгалангийн уулын зүүн этгээд Заг Сүүжийн говиос зүүн, зүүн хойд зүгт Өмнөговь аймгийн Баян-Овоо, Ханбогд⁵⁰, Дорноговийн Хатанбулаг сумын төвөөс хойш хориод км хүртэл гурван зуун арав-хориод км үргэлжлэх урт хоолойд ус, бороо элбэг жил гүн уст гол урсах урт урт сайрууд, задгай ус, нуур, тойром, завсаргүй үргэлжилдэг бололтой харагдсан. Энд л Заг/Юйу (*za.ngâ ~ *ja.ŋa ~ *za.ŋa) гол байх ёстой гэж үзлээ.

Ханьгийн судраар бол энэ хавиас хойд зүгт 600-700 ли (235–280 км) зайд Доусянь уул байх ёстой ажээ. 45-р өргөргөөс урагш хойш гучаад км-т байх магадлалтай. Яг тодорхой газар нэрлэж чадахгүй нь учир нь уул галигийн *to. gam/*twā.grām гэсэн сэргээлт ‘төхөм’ хэмээх үгд ойр ч байр зүйн зургуудад ийм уул тэмдэглээгүй мэт, эсвэл бид дутуу хайсан болов уу. Иймээс энэ удаа чиглэл, байж болох газрыг баримжаалаад зогсё.

* * *

М.э.ө. 60 онд хуйвалдаанаар Хүннүгийн эзэн болсон Уяньгюйди шаньюй ураг угсаа дотроо хядлага явуулж, зүүн гараас шаньюй гарах нөхцөлгүй болтол цэвэрлэх гэж оролдсон нь Хүннүд иргэний дайн дэгдэх гол нөхцөл, үндэс, шалтгаан болжээ. Энэ дайны явцад Хүннүгийн нутгийн гүнд байршилтай хэдэн газар усны нэр ханьгийн түүхэнд тэмдэглэгдсэн юм. Тэдгээр газар усны байршлыг тогтоосон судалгааг олж үзээгүй л байна.

Сидунь. Хуханье шаньюйтай үл эвлэрэгч бүлэг ноёд м.э.ө. 58-57 оны өвөл баруун сэцэн ван Босюйтан-ыг Туци шаньюй гэж өргөмжилжээ. Шаньюй болоод тэрбээр, Хуханье шаньюйд ялагдаж амиа хорлосон Уяньгюйди шаньюйн орд байсан газарт бас өргөөлжээ. Босюйтан нь шаньюй болоод удалгүй цэрэг цуглуулж, Гихоушанийг довтолж, ялаад түүний сууж байсан, хүннүгийн язгуурын нийслэлтэй нутагт хоёр хүүгээ суулгаж, зүүн, баруун *гули* ванд болгож, өөрөө буцсан баримт үндэслэж дээрх саналыг хэллээ.

Туци шаньюй удалгүй дахин цэрэглэж, баруун зүгт довтолж 40 мянга хүн эсвэл 4 түмт цэрэгтэй болж хүч чадал нь нэмэгдсэн Гули (*ka.ŋj) шаньюйг Хуге, Уцзе гэдэг холбоотнуудтай хамт довтолж, баруун хойшоо зугтаалгаад буцжээ. Ирээд Сидунь гэдэг газар шилжиж суув.

А.Шюсслерийн сэргээлтийн тольд буй дуудлага дагавал Сидунь гэж бичих газрын нэрийг – Ундунь, Тидунь, Т’ар-tun, Т’аh-tun, Heih-tun, Tadun (Бичурин, Таскин, де Грот, Паркер, Вайли, Жозеф Яп) гэжээ. Эртний ЛН, ОСМ дуудлага нь – *h̥ip.tuən, *h̥ep.t̥un (Minimal Old Chinese, 37-1, 34-18) болно. А.Шюсслерийн *h̥ep.t̥un, А.Вайлийн Heih.tun анхаарал татсан. Тиймээс Сидунь буюу Heih.tun-ыг Архангайн Хотонт гэж үзэх санал дэвшүүлээ.

⁵⁰ Ялангуяа, Ханбогд суманд уртраг дагуу, залгаа шахуу байрлах Дарьгат, Номгон уулын ардах газар.

Наогу. Гихоушань/Хуханье шаньюйн цэргийг ялсан Туци шаньюй орд өргөөгөө зүүн өмнө⁵¹ зүгт Сидунь/Heih.tun гэдэг газар шилжүүлж байрлажээ. Эндээс Хуханье шаньюйг довтлохоор мордож мянган ли (400 орчим км) явж Наогу гэдэг газар түүний цэрэгтэй тулалдаж ялагдаад амиа хорлож үхжээ. А.Вайли, де Грот нар Ǯō-koō, Ǯō-ko гэж бичсэн бол В.С.Таскин Лугу, Н.Я.Бичурин Нугу гэжээ. Харин Э.Паркер – Наогу гэсэн юм.

Хань улсын бичгийн 94-ийн 3796-д тус үгийн ард «𠂔音乃穀反 ... ‘ру’-гийн дуудлага хөрвүүлэг ‘найгу’»⁵² гэж Янь Шигу (581-645) тайлбарласнаас үзвэл ‘ру’ (𠂔)-гийн Тан улсын үеийн дуудлага нь *nlk байсан бололтой. Тиймээс Наогу (Ругу, 𠂔姑, rugu) гэсэн Э.Паркерын бичлэгийг эшилж хэрэглэлээ.

Наогу/Нугу (Паркер/Иакинф)-ийн сэргээлт:

LN *nok.ka (Minimal Old Chinese, 11-17, 1-1)

OC *njog.kaa (Old Chinese Phonology, 452, 335)

Янь Шигугийн тайлбар, Э.Паркерын бичлэгийг баримталж, гол нь Хотонтоос зүүн тийш мянгаад ли буюу дөрвөн зуугаад км зайтай байх ёстой гэхээр Наогу (*nlk.kə)-аар Нагал уулыг тэмдэглэжээ гэж үзсэн юм. Тэгэхээр Хотонт (Сидунь)-оос хөдөлсөн Туци шаньюйн захирсан хүннүгийн баруун гарын 60 мянга (эсвэл 6 түмт) цэрэг зүүн зүгт мянган ли/400-аад км давшаад, тэднийг ирэхийг хүлээж Нагал (Наогу) ууланд байр хийж бэлдсэн Хуханье шаньюйн захирсан хүннүгийн зүүнгарын 40 мянга (эсвэл 4 түмт) цэрэгтэй 56 оны дундуур, эсвэл хоёрдугаар хагаст тун ширүүн тулалдаж эцэстээ Хуханье ялсан үйл явдлыг м.э.ө. 56 оны Нагал уулын тулалдаан гэж нэрлэж болох юм.

М.э.ө. 58 оны Гуцзюй шуй. Энэ газрын хайлт м.э.ө. 56 оны хэрэг явдлаар түүхэнд тэмдэглэгдсэн Сидунь (*Хотонт), Наогу (*Нагал)-тай холбоотой. Цаг хугацааны хувьд Сидунь, Наогу-гаас түрүүлж тэмдэглэгдсэн газар боловч дээрх хоёр газрыг олсны араас залгаж Гуцзюйн тухай өгүүлж байгаа юм. Өөр нэг шалтгаан бол Хуханье шаньюй цэрэглэж Гули шаньюйг бут цохисны дараа Туци шаньюй орд өргөөгөө Сидунь (*həp.tūn)-д нүүлгэж, удалгүй эндээсээ Наогу (*nlk.kə) хүртэл довтолсныг харгалзмаар санагдаж, Гуцзюй-г Наогу, Сидунь-ий баруун талд Архангай аймгийн нутагт байгаа газар гэж таамагласантай холбоотой.

Өмнө нь ашигласан сэргээлтийн толиудаас өөр толь бичиг⁵³ ашиглахад тус үгийн цаана өөр хүннү үг байж болохоор харагдсан тул түүнийгээ хүргэж байна.

Гуцзюйн сэргээлт:

ЕН *kak.tshjâ (Handbook of Eastern Han, Xu 877, 876, 886; Ying 18)

OC *kaʔ.tshjaʔ (Handbook of Old Chinese, 760, 770)

⁵¹ Уул эхдээ баруун өмнө зүгт гэж байгаа. Алдаж бичсэн байх гэж бид үзэж байгаа, эл үзлээ нотлоход тун хэцүү, харин газрын баримжаа буюу байршлаас харвал бидний санал болмоор.

⁵² Ханьшу, 94В, 3796

⁵³ South Coblin W. A Handbook of Eastern Han Sound Glosses. Hong Kong, The Chinese University Press, 1983; Baxter, William H. A Handbook of Old Chinese Phonology. Berlin-New York, Mouton de Gruyter, 1992, Handbook of Old Chinese гэж товчилж эш заана.

Тоба (*Thak.bat) нэрийг тайлбарлахдаа П.Пельо, эртний хятад хэл орчин цагийн хятад хэлнээс илүү олон авиаг тэмдэглэж байсан ч харь үгийн зарим төгсгөлийн гийгүүлэгчийг хүртэл орхиж галиглаж байв⁵⁴ гэж хэлсэн. Гуцзюйг галиглахдаа чингэсэн эсэхийг мэдэхгүй ч сэргээлтээс харвал ялангуяа 1992 оны У.Бакстериин ОС *ka.tshjaʔ сэргээлтийн төгсгөлийн тэмдэгтийн оронд гийгүүлэгч байжээ гэж төсөөлбөл *ka.tshia(r) гэх алтай, монгол хэлний үг байж болохоор.

Сидунь (Хотонт)-ий байршлыг яг олсон гэвэл *ka.tshia(r) нь Монголын нууц товчоонд гардаг Хангайн Хачир ус байж болох юм. Тэнд “Таян хан Хангайн Хачир усунаа ажгуу. ... Хачир усунаас хөдөлж Тамир уруу[дан] явуут [дундаа] Орхоныг гэтэлж ...”⁵⁵ гэж мэдээлдэг. Зүг чигийг нь эсрэг болгож Тамирыг өгсүүлбэл Хачир ус хүрэх нь. Өнөөдрийн Их тамир сумын нутагт хайх хэрэгтэй. Хотонт буюу Сидунь-ээс баруун хойшоо гэсэн үг. Гэхдээ Д.Базаргүр, Д.Энхбаяр нар 1204 онд Таян ханы өргөөлж байсан Хангайн Хачир усыг Архангай аймгийн Өндөр улаан уулын баруун өмнөд хормой, Зуун модны гол-Хануйн бэлчир гэж зуржээ.⁵⁶ Тамирт ойрхон нутаг.

* * *

Өгүүллийн төгсгөлд Хүннүгийн засаг захиргааны нэгж судалгааны гол цөм болох Хүннү хэдэн гарын зохион байгуулалттай байсан бэ? гэдэг асуултад товч хариулахыг оролдъё.

Эхлээд *түмт* гэсэн нэгж, *гарт* хувааж захирдаг тогтолцоог анх хэзээ тэмдэглэснийг сонирхъё. Бага хүүгээ шаньюй болгохын тулд ууган хүүгээ зольж, Юэчжид барьцаагаар явуулж Юэчжийг довтлоход зугтаж чадсан Модуны эр зоригийг үнэлсэн Түмэн шаньюй түмтийн ноён (ваньги) болгодог. М.э.ө. 209 оны намраас өмнө нэг-хоёр жилд болж өнгөрсөн үйл явдал байх, нэг ёсны м.э.ө. 211/209 он гэхэд *түмтүүд* бүрэн хэлбэржихсэн засаг захиргаа – өмч/эзэмшлийн үндсэн нэгж байжээ. Харин түмтийг бүлэглэж захирах гол арга *гар* (жигүүр)-ын тухай мэдээ, Модуны хаанчлалын эхэнд тэмдэглэгджээ. М.э.ө. 202 оны 2-р сард байгуулагдсан Хань улстай тулалдаж байсан *лоуфаньчууд* болон Лю Баны эсрэг тэмцэж байсан язгууртнуудын хүсэлтээр Модун шаньюй м.э.ө. 201/200 оны өвөл⁵⁷ 10 мянган цэрэгтэй (ө.х. 2 түмт⁵⁸ гэсэн үг) цэрэгтэй *зүүн, баруун* сэцэн ванг илгээж босогч жанжин нарт тусалжээ.⁵⁹ Хэзээ, хэддүгээр зуунд түмт ба гар үүссэнийг одоохондоо хэлж чадахгүй ч ийм бүтэц тогтолцоо бүрэн хэвшиж, үүргээ гүйцэтгэхэд хугацаа шаардлагатай гэж үзвэл Хүннү улс бий болохтой хамт зэрэг

⁵⁴ Pelliot P. L'Origine du nom de «Chine» – TP. Ser. II, Vol. XIII. Leide, 1912, p. 732

⁵⁵ МНТ §§ 194, 195

⁵⁶ Базаргүр Д., Энхбаяр Д. Чингис хаан. Түүхэн газар зүйн атлас. УБ., 1996, т. 34, F-11

⁵⁷ М.э.ө. 201 оны 11-р сарын эхнээс – м.э.ө. 200 оны 2-р сарын эхний хооронд үхэр жилийн өвөл болжээ.

⁵⁸ Тус бүр 5000 цэрэгтэй түмт гэсэн үг. Уг нь, эх газрын баримжаат цэргийн системээр *дивиз*-тэй тэнцэх ч нөгөө тогтолцоогоор орон тоог нэмж дэлгэсэн *бригад* шиг.

⁵⁹ Сыма Цянь. Исторические записки (Ши цзи). Том VIII. Перевод с китайского Р.В.Вяткина и А.М.Каарапетьянца, комментарий Р.В.Вяткина, А.Р.Вяткина и А.М.Каарапетьянца, вступительная статья Р.В.Вяткина. Москва, Издательская фирма «Восточная литература» РАН., 2002, стр. 132

ч үүссэн байж мэднэ. Харин өнөөдрийн түвшнээр бол арваад жилийн зайтай харь улсын түүхэнд тэмдэглэгдсэн *түмт, гарын* тухай мэдээг үндэслэвэл м.э.ө. III зууны төгсгөл гэхэд гарын тогтолцоо, засаг захиргааны түмт гэсэн нэгж хүннүгийн төрийн байгууламжийн салшгүй хэсэг болж, үйлчилж байсан нь тодорхой болж байна.

Хань улсын түүхч Сыма Цянь-ий «Түүхийн тэмдэглэл», Бань Гу-гийн «Хань улсын бичиг»-т буй Хүннүгийн зүүн, баруун хоёр гарын анхны байршил, түүний өөрчлөлтийн талаар дурдсан мэдээг эхлээд сонирхъя:

М.э.ө. III/II зууны заагаас – м.э.ө. 105 он

Зүүн талын бүх ван, захирагчид Шангу-гаас зүүн тийш Хуйхэ, Чаосянь хүртэлх газарт амьдран суудаг. Баруун талын бүх ван, захирагч нар Шангюнь-аас баруун тийш Юэчжи, Ди, Кян хүртэлх нутагт амьдардаг. Шаньюйн орд Дай, Юньжун тойргийн харалдаа нутагт байдаг (Таскин 1968 оны орчуулга).

Зүүн гарын бүх ван, жанжин нь Шангу (мужийн) өөдөөс харан, цааш дорно зүгт Хуйхэ, Чаосяньтай хиллэн зүүн гарт нутаглана. Баруун ван, жанжин нар Шанцзюнь (мужийн) өөдөөс харан, мөн цааш юэчжи, ди, цян нартай хиллэн баруун гарт оршино. Шаньюйн өргөө нь Дай, Юньжун (мужийн) өөдөөс харан байрладаг (Г.Сүхбаатар 1980 оны хэвлэл).

Зүүн зүгийн бүх ван, удирдагчид зүүн мужид нутаглана. Шангу-гийн өөдөөс харж суух тэд зүүн тийш Вэймо, Чаосянь-тай залгах нутагт байдаг.

Баруун зүгийн ван, удирдагчид баруун мужид нутаглана. Шангюнь-ий өөдөөс харж суух тэд цаашаа өрнө зүгт Юэчжи, Ди, Кян-тай залгах нутагт байдаг. Шаньюйн хувьд түүний орд Дай ба Юньжуны өөдөөс харж байдаг (Энно Гилийн 2011 оны орчуулга).

Зүүн ван, цэргийн ноёд Шангу-гаас дорно зүгт Хуймо, Чаосянь хүрдэг зүүн талд байдаг. Баруун ван, цэргийн ноёд Шангюнь-аас баруун тийш Ди, Кян-тай хил залгах баруун талд суудаг. Шаньюй, Дай, Юньжун мужийн умард зүгт оршдог ордтой.⁶⁰

М.э.ө. 105 – м.э. 49 эсвэл I/II зуун хүртэл

[М.э.ө. 105 онд Увэй шаньюй нас нөгчсөний] дараа [түүний хүү Ушилу] шаньюй баруун хойд зүгт бүр цаашилсан тул зүүн гарын цэрэг Юньжуны өөдөөс харж, харин баруун гарын цэрэг Цзюцюань ба Дуньхуаны эсрэг талд байрлах болжээ (Таскины 1968 оны орчуулга).

Увэй шаньюй арван жил төр бариад үгүй болов. Түүний хүү Чжаньшилу сууринд залрав. ... үүний дараа шаньюй баруун хойд зүгт үргэлжлүүлэн ухарчээ. Түүний цэргийн зүүн жигүүр Юньжуны харалдаа нутгийг, баруун жигүүр нь Цзюцюань ба Дуньхуаны харалдаа нутгийг эзлэн суув (Жозеф Япын 2019 оны орчуулга).⁶¹

⁶⁰ Таскин В.С. Материалы по истории сюнну (по китайским источникам). Предисловие, перевод и примечания. Москва, Издательство «Наука», ГРВЛ., 1968, стр. 40; Сүхбаатар Г. Монголчуудын эртний өвөг. Хүннү нарын аж ахуй, нийгмийн байгуулал, соёл, угсаа гарвал (МЭӨ IV – МЭ II зуун). УБ., ШУАХ., 1980, т. 54; The Hsiung-nu, Memoir 50. Translated by Enno Giele – The Grand Scribe's Records. Volume IX. The Memoirs of Han China, Part II by Ssu-ma Ch'ien. Edited by William H. Nienhauser, Jr. Bloomington, Indiana University Press, Nanjing, Nanjing University Press, 2011/2019, pp. 262-263; Yap, Joseph P. The Western Regions, Xiongnu and Han. A Collection of Chapters from the Shiji, Hanshu and Houhanshu. Translated and annotated. 2019, p. 290

⁶¹ Yap, Joseph P. The Western Regions, Xiongnu and Han. A Collection of Chapters from the Shiji, Hanshu and Houhanshu. Translated and annotated. 2019, p. 58; Yap, Joseph P. The Western Regions, Xiongnu and Han. A Collection of Chapters from the Shiji, Hanshu and Houhanshu. Translated and annotated. 2019, p. 323

Хүннүгийн хоёр гар, шаньюйн ордын байрлалыг заасан мэдээг эрдэмтэд судалж санал, үзэл баримтлалаа толилуулж иржээ. Тэднээс нэг судалгааг төлөөлүүлж хүргэе. Дээрх мэдээг үндэслэж Ма Чаншоу – зүүн гарын өмнө хязгаарын баруун зах нь Өвөр Монголын Цахар, түүнээс зүүн тийш орших Ляосийн Пинюань бол зүүн зах нь болно, эндээс хойш орших БНМАУ-ын Онон, Хэрлэн голын сав нутаг нь зүүн гарт багтана гэж үзжээ. Баруун гарын нутгийн өмнө хязгаарын зүүн зах⁶² нь Алаша хошуу, Эзэн хошуу бол баруун зах нь Синьцзяний Зүүнгарын сав, Таримын савын умард хэсэг болох ба хойш орших БНМАУ-ын Сэлэнгээс Ховд хүртэлх нутаг баруун гарт багтана гэж дүгнээд, шаньюйн орд өргөө Орхон голын зүүн эргийн Хөшөө Цайдамд байдаг гэж бичжээ.⁶³ Ма Чаншоугийн судалгаа нь Хүннүд гурван гарын зохион байгуулалт байдаг, шаньюйн орд өргөө Орхоны савд бий гэж үздэг, олон нийтийн дунд ихэд түгсэн үзлийг илэрхийлсэн бичвэр болно. Бас нэг ийм томьёолол бий.

Ма Чаншоугийн үзлийг Г.Сүхбаатар хуваалцдаг ажээ. 1995 оны бэсрэг цуврал-зохиолд “Хүннү улс шаньюйн эзэмшлийн гол хэсэг, зүүн баруун гар гэх гурван үндсэн хэсэгт хуваагдана”⁶⁴ гэж бичиж дүгнэсэн нь монгол эрдэмтдийн баримталдаг үзэл баримтлалыг бүхэлд нь төлөөлж, илэрхийлж чадах томьёолол гэхэд болно.

Бичгийн дурсгалд үлдсэн баримт үндэслэсэн дээрх үзлийг монголын археологичид археологийн судалгаагаар батлахыг оролдсон. Тэгэхдээ, гурван гарын зохион байгуулалтыг анх удаа Модун зохиож хэрэглэсэн гэж бас давтаж алдсан байдаг. З.Батсайхан 2002 онд “Маодун”⁶⁵ шаньюй хөрш аймгуудыг амжилттай довтолсны дараагаар авсан анхны арга хэмжээ бол улсаа зүүн, баруун, төвийн гэсэн гурван жигүүр⁶⁶ болгон хэд хэдэн зэрэг дэв бүхий ноёдоор захируулсан [явдал] байлаа”⁶⁷ гэжээ. Энэ үзэл баримтлалыг тодорхой дурсгалын байрлалтай холбосон судалгааг ч манай археологичид хийсэн. Тухайлбал, Ч.Ерөөл-Эрдэнэ 2015 оны бүтээлдээ “хятад сурвалжид тэмдэглэснээс үзэхэд Модун шаньюй улсаа төв, зүүн, баруун жигүүр болгон гурав хуваасан нь цэрэг, стратеги, газар зүйн талаас төдийгүй эдгээр нутагт оршиж байсан угсаатны бүрэлдэхүүний онцлогтой холбоотой хэрэг” гэж үзээд улмаар язгууртны гэж судлаачид нэрлэж заншсан булш дурсгалын байрлалыг харгалзах З.Батсайханы аргыг хэрэглэж – Дорнод Монголын язгууртны цогцолбор дурсгал бол зүүн жигүүрийн, Баруун Монголын Тахилтын хотгор, Овооно хар ба Тувагийн Бай-даг (Баян таг) II гэсэн оршуулгын газар нь баруун жигүүрийн ихэс, язгууртны оршуулга, төв хэсэгт Ноён уул, Гол

⁶² Баруун гарын зүүн захыг Шэньси мужийн Сүйдэ сяниэс хойших Өвөрмонголын Алаша, Эзэн хороо (Сүхбаатар Г. Монголчуудын эртний өвөг. Хүннү нарын аж ахуй, нийгмийн байгуулал, соёл, угсаа гарвал (МЭӨ IV – МЭ II зуун). УБ., ШУАХ., 1980, т. 55) гэж Г.Сүхбаатар эш татахдаа бичжээ.

⁶³ Ма Чаншоу. Бэйдэ юй Хүннү. Чунвэнь шужу, 2022, т. 77 (хятадаар)

⁶⁴ Сүхбаатар Г. Хүннү улс (МЭӨ 209 – МЭ II зуун) – Монголын түүхийн хураангуй хэрэглүүн. II цуврал. Редактор Д.Хүүхэнбаатар. МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 1995, т. 3

⁶⁵ Модун гэсэн үгийн нэг хувилбар, гэхдээ Маодун гэж Г.Сүхбаатар бичдэг.

⁶⁶ Гол, хоёр жигүүр гэж хэлэх байх.

⁶⁷ Батсайхан З. Хүннү /Археологи, угсаатны зүй, түүх/. УБ., МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2002, т. 145-146

мод, Гол мод II оршуулгын газар байна гэж дүгнэжээ.⁶⁸ Дээр толилуулсан үзэл баримтлалаас зөрсөн санал, үзэл гээд байх юм одоогоор байхгүй. Харин шаньюйн орд өргөөг Туул голд эсвэл Улаанбаатар хавьд байх ёстой гэж гурван эрдэмтэн⁶⁹ хэлсэн зүйл бий.

Хүннү гүрнээс хойш Манж Чин улсын үеийн Халхын нутаг дэвсгэрт байсан, гарт хувааж захирдаг чухал тогтолцоо нь зөвхөн хоёр гараас бүрдэж байсан уу эсвэл гол ба хоёр гар гэсэн 3 хэсгээс бүрдэж байсан уу гэдгийг эхлээд нягталмаар байгаа юм. 2003 онд хэвлэсэн зохиолдоо *хүннүчүүд* газар нутгаа гурав хувааж байсан гэж үзэж, зургийг нь зурж алдсан, энэхүү өгүүллийг бичигч нь арван хэдэн жилийн өмнөөс эхэлж Хүннү улс гол ба зүүн, баруун гар буюу 3 хэсгээс бүрдэж байсан гэх үзэл баримтлал алдаатай болохыг анзаарч зөвхөн хоёр гартай байжээ, шаньюйн орд, түүнийг тойрсон тусгай том эзэмшил байгаагүй юм байна гэж үзэх болсон. Ер нь Төв/Дотоод Азид оршиж байсан улс гүрнүүд бүгд шахуу хоёрхон гарын зохион байгуулалтай байсан нь тодорхой болсон. Гэхдээ, м.э. III зууны сүүл хагаст задарсан Умард Хүннү улстай зэрэгцэж оршиж байсан Сяньбийн нэгдсэн улс (156-235), болон 1206-1217 оны Их Монгол улсад яах аргагүй *гол, зүүн баруун гар* гэсэн *гуравтын тогтолцоо* байсныг орхиж болохгүй. Анзаарагдах эхний онцлог бол эл гуравтын тогтолцоог маш богино хугацаагаар хэрэглэжээ. Сяньбийн нэгдсэн улсын хувьд зөвхөн Таньшихуай хааны цагт хэрэглэсэн гэж харагддаг. Харин Их Монгол улсын хувьд Мухулай, Боорчи, Наяа ноёдын захирсан зүүн, баруун, төвийн түмэнгийн тогтолцоог 1217 оны Туулын Хар Түнэд болсон их хуралдайгаар өөрчилсөн гэж үзэж болох юм.

Түүхэн мэдээ баримт ба цухас өгүүлсэндээ тулгуурлавал Хүннү улс анхнаас гэхдээ бүр м.э.ө. III зууны сүүлээс их урьд цагт гэхэд хоёртын буюу хоёр гарын тогтолцоотой болчихсон байжээ гэж үзэх санал дэвшүүлж байна.

Увэй шаньюй нас барсны дараа м.э.ө. 105 онд хаан ширээнд суусан Ушилу/Чжаньшилу шаньюй ордоо баруун хойш шилжүүлсэн мэдээгээр хүннүгийн зүүн гар – ханьгийн хилийн Юньчжун тойргийн харалдаа, баруун гар – ханьгийн Цзюцюань-Дуньхуан тойргуудын харалдаа байрлах болсон гэжээ. Өмнөх мэдээнээс байрлалаар ялгарч байгаад түшиглэж хүннүгийн шаньюйн орд болон зүүн, баруун гарын байрлал шилжсэн гэж үзэх үү эсвэл хүннүгийн засаг захиргааны хуваарь, зохион байгуулалтыг ханьгийн түшмэд илүү нарийн тодорхой мэдсэнтэй холбоотой юу гэдгийг ялгаж салгах шаардлага яах аргагүй үүсэж байгаа юм.

Юм л бол *нүүж сууж байдаг* гэж үзэх дуртай дорно-өрнийн дэг сургуулийг дагавал яах аргагүй баруун тийш нүүсэн мэт харагдана. Харин м.э.ө. 129 оноос 119 оны хооронд маш эрчимтэй явагдсан Хүннү-Ханьгийн их дайны явцад *ханьгийхан* дайснаа маш сайн судалж илүү тодорхой мэдэж түүнийгээ тусгаж тэмдэглэсэн гэж үзэж бас болох талтайг орхигдуулмааргүй байна. Тэгээд ч Го

⁶⁸ Ерөөл-Эрдэнэ Ч. Хүннүгийн язгууртны оршуулгын дурсгалын судалгаа. Улаанбаатар, Мөнхийн үсэг ХХК., 2015, т. 32-35

⁶⁹ Э.Паркер (1894), С.В.Киселев (1951), З.Батсайхан (2002) нар сая өгүүлсэн саналыг хэлсэн. Э.Паркер зохиолоо 1893/1894 онд дуусгасан гэдэг. Харин С.В.Киселев номоо 1927 онд эхэлж 1947 онд дуусгажээ.

Цзи, Ван У, Ян Синь, Лу Чунго, Су У нарыг м.э.ө. 112-101 оны хооронд бараг л тасралтгүй шахуу илгээж, хүннүгийн шаньюйг айлган сүрдүүлэх, аргадаж нийслэлдээ ирүүлэхийг оролдсон, янз бүрийн арга саам хэрэглэж хүчийг нь сулруулж, дор хаяж түшмэг улс болгох гэж оролдсоныг сануулах юун. Эдгээр элч нар хүннүгийн нутгаар зүгээр яваагүй нь лавтай, өөрөөр хэлбэл тэд нарын авчирсан мэдээллийг Сыма Цянь бичиж үлдээсэн нь бүр эрт цагт магад м.э.ө. 199-198 онд Хүннүд очиж гэрээ байгуулахдаа Лю Цзиний олж мэдсэнээс илүү нарийн байгаа учир зөрж байгаа мэт харагдах байх. Тиймээс бид, лав өнөөдрийн түвшиндээ хүннүгийн хоёр гарын тогтолцоо/хуваарь нэлээд тогтвортой байсан гэж үзлээ. Аль нь ч бай Шангу ба Юньчжун нь чухал баримжаа болох зүг чиг.

Хүннүгийн хоёр гарын байрлалыг заасан эхний мэдээнд ‘нуугдсан’ өөр нэг чухал баримт бол хүннүгийн улс төрийн байршил бөлгөө. Шаньюйн ордыг хаагуур байрлаж байсныг заасан эл баримт нь *Хүннүгийн улс төрийн төвийг Орхоны хөндийд, Хархорин хавьд байрлуулах их дуртай дотоод, гадаадын судлаачдын алдаатай боловч амь бөхтэй үзлийг хангалттай ‘бут ниргэхэд’ үндэс язгуур болох маш чухал баримт*. БНХАУ-ын эрдэмтдийн судалж зурж хэвлүүлсэн түүхэн газрын зургийн атласт Дай хотыг одоогийн Сангань голд цутгах, Хулю (тэр цагт Ци-и гэж нэрлэж байжээ) голын өмнө эрэгт байрлах одоогийн Юйсянь хотоос зүүн хойш 10-11 км-т байснаар, Юньчуныг Хөх хотоос баруун урагш Тогтох хотын чигт 42 орчим км-т байснаар зуржээ. Дай хот 115-р уртрагийн баруун талд их ойрхон бол Юньчжун хот 111-р уртрагийн зүүхэн талд байсан гэсэн үг. Эдгээр уртрагийн ойр байдаг. Монголын том хотыг заа гэвэл Өндөрхаан, Чойбалсан/Баянтүмэн хотыг нэрлэж болно. Юун Орхоны хөндий, хамаагүй хол бус уу. Дашрамд цухас өгүүлэхэд бид хүннүгийн эхэн үеийн улс төрийн төв нь Хэрлэнгийн сав дагуу түүний баруун талаас цутгах Галуут хавиар байсан гэж өмнө нэг хэвлэсэн нэг өгүүлэлдээ дурдсанаа дахин сануулъя.

Abstract

In this article, which is an attempt to localize the river, lake and area of the Hunnu's, we hypothesized that several of them were located in the territory of the Dornogobi (East Gobi), Ömnögobi (South Gobi) and Töv (Central) aimags of modern Mongolia. However, the places where the Hunnu's fought among themselves, Gujushui, I think this is the place that the Secret History of the Mongols, mentioned, that is, Qačir Usun in Khangai, and as for Xidun and Naogu, this is Khotont in Arkhangai and Mount Nagal in the Töv (Central) aimag. But most importantly, based on decades of research and detailed work, we came to the conclusion that in the Hunnu Empire there were only two flanks or ‘gar’.



Зураг 3. Хүннүгийн газар усны байришил (М.э.ө. II-I зуун)